



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН
ТОГТОЛЦООНЫ ГАРЫН АВЛАГА

БАЙГУУЛЛАГЫН НЭР	Монгол улсын их сургууль (МУИС)
БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ	Их сургуулийн гудамж – 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
БАРИМТ БИЧГИЙН №	NUM/EOMS/001
ХУВИЛБАР №	01
БОЛОВСРУУЛСАН ОГНОО:	2025-07-21

АГУУЛГА

[A]	Баримт бичгийн хяналтын түүх	5
[B]	Байгууллагын танилцуулга.....	6
[C]	Оршил	7
[D]	Гарын авлагын хамрах хүрээ	9
[E]	Норматив иш таталт	100
[F]	Нэр томъёо, тодорхойлолт.....	10
[G]	Нэр томъёоны тайлбар толь	104
Бүлэг 1:	Байгууллагын төлөв байдал (Дэд бүлэг-4)	
1.1	Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох	16
1.2	Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг ойлгох.....	16
1.3	ББМТ-ны хамрах хүрээг тодорхойлох	17
1.4	ББМТ ба түүний үйл явц.....	18
Бүлэг 2:	Манлайлал (Дэд бүлэг-5).....	19
2.1	Манлайлал ба амлалт	19
2.1.1	Ерөнхий зүйл.....	19
2.1.2	Суралцагчид, үйлчлүүлэгч болон бусад үр шим хүртэгчид анхаарлаа хандуулах	19
2.1.3	Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага	20
2.2	Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого	20
2.2.1	Бодлого боловсруулах	20
2.2.2	Бодлогыг мэдээлэх	20
2.3	Байгууллага дахь үүрэг, хариуцлага эрх мэдэл	21
Бүлэг 3:	Төлөвлөлт (Дэд бүлэг-6).....	21
3.1	Эрсдэл ба боломжид чиглэсэн арга хэмжээ	21
3.2	Боловсролын байгууллагын зорилт, тэдгээрт хүрэх төлөвлөлт.....	22
3.3	Өөрчлөлтийн төлөвлөх.....	23
Бүлэг 4:	Тулгуур хүчин зүйл (Дэд бүлэг-7)	23
4.1	Нөөц	23
4.1.1	Ерөнхий зүйл.....	24
4.1.2	Хүний нөөц	24
4.1.3	Байгууламж	25
4.1.4	Боловсролын үйл явцыг хэрэгжүүлэх орчин	26
4.1.5	Нөөцийн мониторинг, хэмжилт	27
4.1.6	Байгууллагын мэдлэг.....	27
4.2	Чадамж.....	27
4.2.1	Ерөнхий зүйл.....	28
4.2.2	Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага	28
4.3	Мэдлэг, ойлголт	28
4.4	Харилцаа холбооны зорилго.....	28
4.4.1	Харилцаа холбооны зохицуулалт	28
4.5	Баримтжуулсан мэдээлэл	29
4.5.1	Ерөнхий зүйл.....	30
4.5.2	Мэдээлэл бий болгох, өөрчлөх шинэчлэх	30
4.5.3	Баримтжуулсан мэдээллийн хяналт	30
Бүлэг 5:	Ажиллагаа (Дэд Бүлэг-8)	30
5.1	Ажиллагааны төлөвлөлт ба хяналт	30
5.1.1	Ерөнхий зүйл.....	30
5.1.2	Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний тусгай ажиллагааны төлөвлөлт, хяналт	31
5.1.3	Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага	31
5.2	Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлага.....	32

5.2.1	Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагыг тодорхойлох.....	32
5.2.2	Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлагыг мэдээлэх.....	32
5.2.3	Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагын өөрчлөлт.....	32
5.3	Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн, боловсруулалт..	33
5.3.1	Ерөнхийзүйл.....	33
5.3.2	Дизайн ба боловсруулалтын төлөвлөлт	34
5.3.3	Дизайн ба боловсруулалтын орц	34
5.3.4	Дизайн ба боловсруулалтын хяналт	34
5.3.5	Дизайн ба боловсруулалтын гаралт	35
5.3.6	Дизайн ба боловсруулалтын өөрчлөлт.....	36
5.4	Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт	36
5.4.1	Хяналтын төрөл ба хэр хэмжээ	36
5.4.2	Гаднын нийлүүлэгчдэд зориулсан мэдээлэл.....	37
5.5	Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх	37
5.5.1	Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхэд тавих хяналт	37
5.5.2	Тэмдэглэгээ, мөшгөх боломж.....	41
5.5.3	Сонирхогч талуудын өмч.....	41
5.5.4	Хамгаалалт	41
5.5.5	Суралцагчдын өгөгдлийн хамгаалалт, ил тод байдал.....	41
5.5.6	Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт	42
5.6	Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлж эхлэх	42
5.7	Боловсролын гарцын үл тохирлын хяналт	42
Бүлэг 6:	Гүйцэтгэлийн үнэлгээ(Дэд Бүлэг-9).....	43
6.1	Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээ	43
6.1.1	Ерөнхий зүйл	43
6.1.2	Суралцагчид, үйлчлүүлэгчид, үр шим хүртэгчид, ажилтнуудын сэтгэл ханамж	44
6.1.3	Бусад мониторинг, хэмжилтийн хэрэгцээ	44
6.1.4	Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний арга.....	45
6.1.4	Дүн шинжилгээ ба үнэлгээ.....	45
6.2	Дотоод аудит.....	46
6.3	Менежментийн дүн шинжилгээ	46
Бүлэг 7:	Сайжруулалт (Дэд Бүлэг-10)	47
7.1	Үл тохирол ба залруулах арга хэмжээ.....	47
7.2	Тасралтгүй сайжруулалт	47
7.3	Сайжруулах боломж.....	47
Хавсралт :		

[A] Баримт бичгийн хяналтын түүх

Хяналтын дугаар	Бүлгийн дугаар	Хуудасны дугаар	Одоогийн хяналтын дугаар.	Шинэчлэх огноо	Өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл	Баримт бичгийн өөрчлөлтийн мэдэгдлийн дугаар

[B] МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Сургууль (МУИС) нь 1942 онд байгуулагдсан, Монгол Улсын ууган бөгөөд нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж буй үндэсний хэмжээний их сургууль юм.

МУИС нь:

- Бүрэлдэхүүн 7 сургууль,
- Орон нутаг дахь 3 салбар сургууль,
- Үндэсний статустай 4 хүрээлэн,
- Судалгааны болон дэмжих чиг үүрэг бүхий бусад нэгжүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

МУИС бакалавр, магистр, докторын түвшний боловсрол олгохоос гадна эрдэм шинжилгээ, судалгааны өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа эрхэлж, эрдэмтэн багш, ажилтан, суралцагчдынхаа хамтаар Монгол Улсын эрдэм оюуны хөгжлийг манлайлан чиглүүлж байна. МУИС нь 80 гаруй жилийн түүхэн уламжлал, туршлагынхаа үндсэн дээр өнөөдөр Монголын дээд боловсролын салбарын хөгжилд тэргүүлэх байр суурь эзэлж, шинжлэх ухаан, боловсролын олон улсын түвшний хамтын ажиллагааг өргөжүүлэн, дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай мэдлэгт суурилсан их сургууль болох зорилт тавин ажиллаж байна.

МУИС нь 1942 онд байгуулагдсанаас хойш Монгол Улсын дээд боловсролын тогтолцооны суурийг бэхжүүлэх (1942–1961), боловсон хүчин бэлтгэх (1962–1989), шилжилтийн үеийн сорилтыг шийдвэрлэх (1990–2000), зах зээлийн эдийн засагт шилжсэн үеийн (2011–2020), судалгаа, эрдэм шинжилгээг эрчимжүүлэх (2016–2024) (МУИС-ийн 2016–2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн нөхцөл байдлын шинжилгээ. 2023), стратегийн үе шатуудыг амжилттай хэрэгжүүлж ирсэн бөгөөд одоо 2025–2030 оны стратеги төлөвлөгөөгөө хэрэгжүүлэн ажиллаж байна.

2024-2025 оны хичээлийн жилд МУИС-ийн бүрэлдэхүүн болон салбар 10 сургуульд бакалавр, магистр, докторын түвшний 224 хөтөлбөрийг хэрэгжүүлж, 26426 орчим суралцагч, 1326 гаруй багш, ажилтантай үйл ажиллагаа явуулсан. 2023 онд БШУЯ-аас тодорхойлсон дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбээр 1-д эрэмбэлэгдэхдээ сургалт 94%, эрдэм шинжилгээ 91%, гадаад харилцаа 41%, орчин үйлчилгээ 73%-р үнэлэгдсэн нь МУИС үндэсний хэмжээнд сургалт, эрдэм шинжилгээ тодорхой түвшинд шаардлага хангаж байгааг илэрхийлэх боловч гадаад харилцаа, орчин үйлчилгээнд эрс өөрчлөлтийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэж байна (МУИС Стратеги төлөвлөгөө 2025-2030) Түүнчлэн дэлхий нийтийн болон дотоодын улс хоорондын ажиллах хүчний шилжилт, аж үйлдвэрийн 4, 5 дахь хувьсгал, хүн амын өсөлт, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт зэрэг гадаад, дотоод хүчин зүйлс нь МУИС-ийн өрсөлдөх давуу тал, стратегийг дахин харж, тодорхойлох шаардлагатайг харуулж байна.

[C] ОРШИЛ

Энэхүү гарын авлага нь Монгол Улсын Их Сургуульд хэрэгжүүлж буй ISO 21001:2018 стандартын шаардлагын дагуу боловсруулсан Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо (ББМТ)-г тодорхойлох үндсэн баримт бичиг мөн.

МУИС-ийн нэгж, бүрэлдэхүүн, салбар сургууль, захиргаа аж ахуйн нэгжүүдийн заавал мөрдөх бодлого, журмын эмхэтгэлийн тойм болж буй энэхүү гарын авлага нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн дараах зорилгыг агуулна. Үүнд:

- **ББМТ-ны бүтцийг тодорхойлох:** МУИС-ийн ББМТ-ны үйл явц, тэдгээрийн харилцан хамаарал, нэгжүүдийн хоорондох хариуцлагын хуваарилалтыг тодорхой тайлбарлах;
- **Чадамжийг батлах:** Суралцагчид болон бусад үр шим хүртэгчдийн хэрэгцээ шаардлага, мөн зохицуулалтын шаардлагыг бүрэн хангах МУИС-ийн чадварыг баталгаажуулах;
- **Тасралтгүй сайжруулалтыг дэмжих:** Тогтолцооны үр дүнтэй байдлыг хангаж, суралцагч болон сонирхогч талуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сайжруулалтын үйл явцыг тогтмол дэмжих.

Энэхүү гарын авлагад дурдсан бодлого, журам нь МУИС-ийн бүх түвшинд үр дүнтэй, үр ашигтай үйл ажиллагааг дэмжиж, байгууллагын чиг үүргийг стандартчилах, хялбарчлах үндэс болно. Үүний үр дүнд чанартай боловсролын үйлчилгээг тогтвортой хүргэх, байгууллагын урт хугацааны хөгжлийг хангах боломж бүрдэнэ.

АЛСЫН ХАРАА

Дэлхийн түвшний судалгааны их сургууль болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид шинжлэх ухааны хөгжлийн үндэсний түүчээлэгчийн хувьд эрдэм шинжилгээ, сургалтаар манлайлж, нийгмийг хөгжүүлэгч хүч болсон тэргүүлэх их сургууль байна.

ҮНЭТ ЗҮЙЛС:

МУИС-ийн ББМТ-ны хэрэгжилт нь дараах үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлана.

- Академик Эрх Чөлөө: Оюуны чөлөөт, нээлттэй эрэл хайгуул хийх, түүний үр дүнг чөлөөтэй илэрхийлэхийг бүх талаар дэмжиж, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх.
- Ёс Зүй: Багш, судлаач, оюутны болон хувь хүний ёс зүйг дээдлэн, үнэнч шударга байж, бусдад хүндэтгэлтэй хандах.
- Уламжлалын Бахархал: Дээд боловсролын анхдагч, шинжлэх ухааны суурь салбарыг хөгжүүлэгч МУИС-аар овоглосон хэн бүхний бахархлыг бадраах.
- Бүтээлч Байдал: Бүтээлч сэтгэлгээгээр инновацлаг шийдэл, өөрчлөлтийг дэмжин, үр дүнд төвлөрч бүтээмжтэй ажиллах.

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэх стратегийн тэргүүлэх таван чиглэл нь ББМТ-ны бодлого, зорилтуудын үндэс болно.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1.ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ – Судалгаа, инновацын чадамжийг бэхжүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2.СУРГАЛТ - Дэлхийд өрсөлдөх чадвартай оюунлаг иргэдийг бэлтгэнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3.НИЙГМИЙН ОРОЛЦОО – Хамтын ажиллагаагаар нийгэмд тогтвортой үнэ цэнийг бүтээнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4.НӨӨЦ – Байгууллагын нөөцийн оновчтой удирдлагыг хөгжүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5.ЗАСАГЛАЛ – Сайн засаглалыг төлөвшүүлж, менежментийн чадамжийг бэхжүүлнэ.

МУИС-ИЙН 2025-2030 ОНЫ СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛТУУД

Стратегийн
тэргүүлэх чиглэлүүд зорилго Хараа

Стратегийн зорилгууд

Үнэт Уриа
зүйлс үг

ДЭЛХИЙН ТҮВШНИЙ СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ БОЛНО

БИД ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТҮҮЧЭЭЛЭГЧИЙН ХУВЬД ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТААР МАНЛАЙЛЖ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭГЧ ХҮЧ БОЛСОН ТЭРГҮҮЛЭХ ИХ СУРГУУЛЬ БАЙНА.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА, ИННОВАЦЫН ЧАДАМЖИЙГ БЭХЖҮҮЛНЭ.		СУРГАЛТ ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ ОЮУНЛАГ ИРГЭДИЙГ БЭЛТГЭНЭ.		НИЙГМИЙН ОРОЛЦОО ХАМТЫН АЖИЛЛАГААГААР НИЙГЭМД ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭНИЙГ БҮТЭЭНЭ.		НӨӨЦ БАЙГУУЛЛАГЫН НӨӨЦИЙН ОНОВЧТОЙ УДИРДЛАГЫГ ХӨГЖҮҮЛНЭ.		ЗАСАГЛАЛ САЙН ЗАСАГЛАЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЖ, МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАМЖИЙГ БЭХЖҮҮЛНЭ.					
Судалгаа, инновацын орчин нөхцөл, чадамжийг сайжруулна.	Олон улсын өндөр түвшний эрдэм шинжилгээний ажлуудыг нэмэгдүүлнэ.	Судалгаа, инновацаас олох орлогыг нэмэгдүүлнэ.	Сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийж шилдэг хөтөлбөрөөр ялгарна.	Оюутны хөгжлийг дэмжиж суралцахууд суралцсан иргэдийг төлөвшүүлнэ.	Сургалтын олон талт хэлбэрийг ашиглаж хамрах хүрээг өргөжүүлнэ.	Нийгмийг хөгжүүлэгч тэргүүлэх судалгааны байгууллага байна.	Нийгэмд эерэг өөрчлөлтийг бий болгоход нөлөөлөх шинжлэх ухаанч, соён гэгээрүүлэгч, академик Тогтвортой хөгжлийг дэмжсэн, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны орчныг бүрдүүлнэ.	Хүний нөөцийн бодлогоор авьяастны төвлөрлийг бий болгоно.	Сурах, ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлнэ.	Орлогын олон талт эх үүсвэрийг бүрдүүлж,үр ашигт чиглэсэн хөрөнгө оруулалтын тогтолцоог бий болгоно.	Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг олон улсын сайн засаглалын туршлагад нийцүүлнэ.	Цахим засаглалыг хөгжүүлж, байгууллагын менежментийн чадамжийг бэхжүүлнэ.	Стратегийн хэрэгжүүлэлтийн үйл явцыг боловсронгуй болгоно.

Эрдмийн хэт цахиваас хөгжлийн гал бадармуй.

Академик эрх чөлөө, Ёс зүй, Уламжлалын бахархал, Бүтээлч байдал

Стратегийг хянах гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт

МУИС-ИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

МУИС-ийн Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого нь их сургуулийн алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд олон улсын түвшний эрдэм шинжилгээ, инновац, сургалт, судалгаа, нийгмийн оролцоо, сайн засаглалыг хөгжүүлэхэд чиглэнэ. Энэхүү бодлогоор дамжуулан сонирхогч болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангаж, үндэсний хэмжээнд баталгаажсан байр сууриа бэхжүүлэхийн зэрэгцээ олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа тасралтгүй үнэлж, сайжруулахыг эрмэлзэнэ.

МУИС нь оюутан, багш, ажил олгогч, үйлдвэрлэл эрхлэгч, төрийн байгууллага, олон нийтийн нийтлэг хэрэгцээ, хүлээлтэд байнга анхаарч, холбогдох бүх шаардлагыг дагаж мөрдөхөөс гадна боловсролын байгууллагын менежментийн тогтолцоогоо улам сайжруулж, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж, оюуны өмчийг эрхэмлэн ажиллана.

МУИС-ийн боловсролын бодлого дараах чиглэлд төвлөрнө:

- Судалгаа, шинжилгээ, инновацын менежментийн тогтолцоог сайжруулж, эрдэм шинжилгээний бүтээлч орчныг бүрдүүлж, багш, судлаач, суралцагчдын чадавхыг тасралтгүй хөгжүүлнэ;
- Боловсролын инновацыг ашиглан сургалтын хөтөлбөрийг шинэчилж, өрсөлдөх чадалтай, уян хатан тогтолцоог бий болгож, оюутнуудад үндэсний болон олон улсын түвшний чанартай боловсрол, эрдмийн зэрэг эзэмших боломж бүрдүүлнэ;
- Үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, хэрэгжүүлэх бүх шатанд оюутан болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангана;
- Нийгэм, эдийн засгийн тэргүүлэх зорилгод нийцсэн боловсролын үйлчилгээгээр нийгэмд үр өгөөжөө хүргэнэ;
- Оролцогч талуудын идэвхтэй оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж, тэдний санаа бодлыг тусгах тогтолцоог боловсронгуй болгоно;
- Чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, суралцах, ажиллах, хөгжих таатай, аюулгүй орчноор хангана;
- Ёс зүйд нийцээгүй аливаа үйл ажиллагааг хориглон, эрдэм шинжилгээний бүрэн бүтэн байдал, эрдмийн эрх чөлөөг хамгаална;
- Сайн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлж, бүх хэлбэрийн ялгаварлал, хүчирхийллийг үл тэвчинэ.

[D] ХАМРАХ ХҮРЭЭ

ISO 21001:2018 стандартын бүх заалтууд МУИС-д хамаарна.

- Менежментийн баг гарын авлагын бүх үзэл баримтлал, зарчмуудыг мөрдөнө.
- ББМТ-г үр дүнтэй хэрэгжүүлэх ерөнхий үүрэг, хариуцлагыг Менежментийн баг хүлээнэ.

[E] НОРМАТИВ ИШ ТАТАЛТ

Баримт бичиг	Хувилбар	Гарчиг
-----------------	----------	--------

ISO 21001	2018	Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо - Ашиглах заавар бүхий шаардлага
-----------	------	--

[F] НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ

Тогтолцоотой холбоотой нэр томьёо	
Шаардлага	Ерөнхийдөө зөвшөөрөгдсөн буюу албан журмын шинжтэй, тогтоосон хэрэгцээ буюу хүлээлт
Шинж чанар	Ялгагдах онцлог
Мөшгөгдөх байдал	Объектын байршил, хэрэглээ эсвэл түүх мөшгөх чадвар
Тогтолцоо	Харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэлтэй элементүүдийн багц
Менежментийн тогтолцоо	Бодлого ба зорилтуудыг тодорхойлох, харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэлтэй, байгууллагын элементүүдийн багц ба тэдгээр зорилтуудыг хангах үйл явцууд
ЕOMS/ББМТ Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо	Боловсролын байгууллагатай холбоотой байгууллагыг удирдан чиглүүлэх, хянах менежментийн тогтолцоо
ЕOMS/ББМТ-ны бодлого	Дээд удирдлагаас албан ёсоор илэрхийлсэн ББМТ-ны гүйцэтгэлтэй холбоотой байгууллагын ерөнхий зорилго, чиглэл
ЕOMS /ББМТ-ны зорилт	Байгууллагын зорилгод хүрэхийн тулд ЕOMS/ББМТ-ны гүйцэтгэлийн зорилт
Менежмент	Байгууллагыг удирдан чиглүүлэх, хянах үйл ажиллагааг зохицуулах.
Дээд удирдлага	Байгууллагыг дээд түвшинд удирдан чиглүүлж, хянадаг хувь хүн ба бүлэг хүмүүс
Байнгын сайжруулалт	Шаардлагыг биелүүлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд давтагдах үйл ажиллагаа
Үр дүнтэй байдал	Төлөвлөсөн ажлууд хэр биелж, төлөвлөсөн үр дүнд хүрч байгаа байдал
Үр ашиг	Хүрсэн үр дүн ба ашигласан нөөцийн хоорондын хамаарал
Байгууллагатай холбоотой нэр томьёо	
Байгууллага	Өөрийн зорилтод хүрэхийн тулд чиг үүрэг, үүрэг хариуцлага, эрх мэдэл, харилцан хамаарал бүхий хувь хүн ба бүлэг хүмүүс
Байгууллагын бүтэц	Үүрэг, хариуцлага, эрх мэдэл, хүмүүсийн хоорондын харилцааны зохицуулалт
Дэд бүтэц	Байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээтэй байгууламж, тоног төхөөрөмж, үйлчилгээнүүдийн зохион байгуулалтын тогтолцоо
Ажиллах орчин	Ажил хийж гүйцэтгэх нөхцөл байдлын багц
Нийлүүлэгч	Бүтээгдэхүүн нийлүүлдэг байгууллага эсвэл хүн
Сонирхогч тал	Байгууллагын гүйцэтгэл эсвэл амжилтад сонирхолтой хүн эсвэл бүлэг
Үйл явц ба бүтээгдэхүүнтэй холбоотой нэр томьёо	
Үйл явц	Орцыг гаралт болгон хувиргадаг харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэлийн багц
Бүтээгдэхүүн	Үйл явцын үр дүн
Төсөл	Цаг хугацаа, зардал, нөөцийн хязгаарлалт зэрэг тодорхой шаардлагад тохирсон зорилгод хүрэхийн тулд эхлүүлсэн болон дуусах огноо бүхий зохицуулалттай, хяналттай үйл ажиллагаанаас бүрдэх өвөрмөц үйл явц.
Журам	Үйл ажиллагаа эсвэл үйл явцыг хэрэгжүүлэх тодорхой арга зам.
Ажлын заавар	Үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэх тухай бичгээр зааварчилгаа.

Тохиролтой холбоотой нэр томьёо	
Тохирол	Шаардлагын биелэлт
Үл тохирол	Шаардлагыг биелүүлэхгүй байх
Согог	Зориулалтын болон заасан ашиглалттай холбоотой шаардлагыг биелүүлээгүй.
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Боломжит үл тохирол эсвэл бусад хүсээгүй нөхцөл байдлын шалтгааныг арилгах арга хэмжээ.
Залруулах арга хэмжээ	Илэрсэн үл тохирол болон бусад хүсээгүй нөхцөл байдлын шалтгааныг арилгах арга хэмжээ
Залруулга	Илэрсэн үл тохирлыг арилгах арга хэмжээ
Нийлүүлэх /Release/	Үйл явцын дараагийн үе шат руу шилжих зөвшөөрөл
Баримт бичигтэй холбоотой нэр томьёо	
Мэдээлэл	Ач холбогдол бүхий өгөгдөл
Баримтжуулсан мэдээлэл / Баримт бичиг	Байгууллага хянаж бас мөрдөж хадгалах шаардлагатай мэдээлэл ба түүнийг агуулж буй баримт бичиг
Үзүүлэлтүүд	Шаардлагыг тодорхойлсон баримт бичиг
EOMS /ББМТ гарын авлага	ISO 21001:2018 стандартад заасан шаардлагыг хангах байгууллагын менежментийн нэгдсэн тогтолцоог тодорхойлсон баримт бичиг
Хадгалагдсан мэдээлэл / Бүртгэл	Хүрсэн үр дүнг харуулсан баримт бичиг эсвэл гүйцэтгэсэн үйл ажиллагааны нотлох баримт
Шалгалттай холбоотой нэр томьёо	
Объектив нотолгоо	Аливаа зүйлийн оршин байгаа эсвэл үнэн эсэхийг батлах өгөгдөл
Магадалгаа /Verification	Тодорхой шаардлагыг хангасан болохыг бодитой нотлох баримтаар магадлах
Шинжлэх	Зорилгодоо хүрэхийн тулд тухайн сэдвийн зохистой байдал, хүрэлцээ, үр нөлөөг тодорхойлоход чиглэсэн үйл ажиллагаа
Аудиттай холбоотой нэр томьёо	
Аудит	Аудитын шалгуурыг хэр хангаж байгааг тодорхойлохын тулд аудитын нотлох баримтыг олж авах, бодитойгоор үнэлэх системтэй, хараат бус, баримтжуулсан үйл явц.
Аудитын хөтөлбөр	Тодорхой хугацаанд төлөвлөсөн, тодорхой зорилгод чиглэсэн нэг буюу хэд хэдэн аудитын багц.
Аудитын шалгуур	Лавлагаа болгон ашигласан бодлого, журам эсвэл шаардлагын багц
Аудитын нотолгоо	Аудитын шалгуурт нийцсэн, шалгах боломжтой бүртгэл, баримтын мэдэгдэл эсвэл бусад мэдээлэл.
Аудитын үр дүн	Цуглуулсан аудитын нотлох баримтыг аудитын шалгуурын дагуу үнэлсний үр дүн.
Аудитын дүгнэлт	Аудитын зорилтууд болон аудитын бүх үр дүнг авч үзсэний дараа аудитын багийн өгсөн аудитын үр дүн.
Аудитлагдах	Байгууллагад аудит хийгдсэн
Аудитор	аудит хийх чадвартай хүн.
Аудитын баг	Нэг буюу хэд хэдэн аудитор аудит хийх
Техникийн шинжээч	Аудитад хамрагдах сэдвийн талаар тодорхой мэдлэг, туршлагатай хүн.
Чадамж	Мэдлэг, ур чадвараа ашиглах
EOMS/ББМТ-той холбоотой нэр томьёо	

ЕОМС/ББМТ гүйцэтгэл	Байгууллагын ЕОМС/ББМТ-ны эрсдэлийн менежментийн хэмжигдэхүйц үр дүн.
Эрсдэл	Тодорхой бус байдлын нөлөө
Ажлын байр	Байгууллагын хяналтын дор холбоотой үйл ажиллагаа явуулдаг аливаа физик байршил.

[G] НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ /АНГЛИ, МОНГОЛ/

Товчлол	Утга
Дээд удирдлага	Ректорын зөвлөл, Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөл
IP	Interested Party /Сонирхогч тал
IL	Issue Log/ Асуудлын бүртгэл
ЕОМСР	ЕОМС Procedures-ББМТ-ны журмууд
ЕОМС	Educational Organization Management System - Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо /ББМТ/
MR	Management Representative - Удирдлагын төлөөлөгч
Functional Heads /Функциональ нэгжийн дарга/	Ректор, проректорууд, нэгжийн дарга нар, сургуулийн захирлууд, эрдмийн зөвлөлийн дарга, удирдах зөвлөлийн дарга,
NCR	Non Conformity Report-Үл тохирлын тайлан
NC	Non Conformance - Үл тохирол
CN	Change Note-Өөрчлөлтийн тэмдэглэл

БҮЛЭГ 1: БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВ БАЙДАЛ (ISO21001:2018 стандарт, бүлэг 4)

1.1 Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох

Монгол Улсын Их Сургууль (МУИС) нь 1942 онд байгуулагдсанаас хойш Монгол Улсын дээд боловсролын тогтолцооны суурийг бэхжүүлэх (1942–1961), боловсон хүчин бэлтгэх (1962–1989), шилжилтийн үеийн сорилтыг шийдвэрлэх (1990–2000), зах зээлийн эдийн засагт шилжсэн үеийн (2011–2020), судалгаа, эрдэм шинжилгээг эрчимжүүлэх (2016–2024) (МУИС-ийн 2016-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн нөхцөл байдлын шинжилгээ. 2023), стратегийн үе шатуудыг амжилттай хэрэгжүүлж ирсэн бөгөөд одоо 2025–2030 оны стратеги төлөвлөгөөгөө хэрэгжүүлэн ажиллаж байна.

2024-2025 оны хичээлийн жилд МУИС-ийн бүрэлдэхүүн болон салбар 10 сургуульд бакалавр, магистр, докторын түвшний 224 хөтөлбөрийг хэрэгжүүлж, 26426 орчим суралцагч, 1326 гаруй багш, ажилтантай үйл ажиллагаа явуулсан. 2023 онд БШУЯ-аас тодорхойлсон дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбээр 1-д эрэмбэлэгдэхдээ сургалт 94%, эрдэм шинжилгээ 91%, гадаад харилцаа 41%, орчин үйлчилгээ 73%-р үнэлэгдсэн нь МУИС үндэсний хэмжээнд сургалт, эрдэм шинжилгээ тодорхой түвшинд шаардлага хангаж байгааг илэрхийлэх боловч гадаад харилцаа, орчин үйлчилгээнд эрс өөрчлөлтийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэж байна (МУИС Стратеги төлөвлөгөө 2025-2030) Түүнчлэн дэлхий нийтийн болон дотоодын улс хоорондын ажиллах хүчний шилжилт, аж үйлдвэрийн 4, 5 дахь хувьсгал, хүн амын өсөлт, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт зэрэг гадаад, дотоод хүчин зүйлс нь МУИС-ийн өрсөлдөх давуу тал, стратегийг дахин харж, тодорхойлох шаардлагатайг харуулж байна.

МУИС-ийн зорилго, нийгмийн хариуцлага, бодлого, стратегийн чиглэлтэй холбоотой, менежментийн тогтолцооны зорьсон үр дүнд хүрэхэд нөлөөлөх дотоод, гадаад нөхцөл байдал, хүчин зүйлийг PESTEL болон SWOT шинжилгээний аргыг ашигладаг.

1.1.1 Макро Орчны Шинжилгээ (PESTEL)

1. Улс төрийн хүчин зүйл (Political)

- **Боловсролын бодлого, хууль эрх зүйн шинэчлэл:** 2023 онд батлагдсан Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль нь нь судалгаа, сургалтын чанар, стандарт, оюутны эрх, үүрэг, багш нарын мэргэжлийн хөгжил, их, дээд сургуулийн удирдлагын бүтэц, санхүүжилт, албан ба албан бус боловсрол зэрэг харилцааг шинээр зохицуулсан.
- **Засгийн газрын тогтворгүй байдал:** Улс төрийн нөхцөл байдал, засгийн газрын солигдох бүрд боловсролын бодлогод өөрчлөлт орох, залгамж чанар алдагдах эрсдэлтэй.

2. Эдийн засгийн хүчин зүйл (Economic)

- **Эдийн засгийн тогтвортой байдал:** Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбарт тулгуурласан хөгжлийн загвартай. Энэ нь боловсролын санхүүжилт, төсвийн бодлогод шууд нөлөөлдөг.

3. Нийгмийн хүчин зүйл (Social)

- **Хүн амын өсөлт, бүтэц:** Залуучуудын эзлэх хувь нэмэгдэж байгаа нь их дээд сургуулиудын элсэгчдийн тоонд эерэг нөлөөтэй. Гэвч хотжилт, хөдөө орон нутгаас шилжих хөдөлгөөн нь зарим бүс нутгийн их сургуулиудын элсэлтийг бууруулж байна.
- **Оюутан залуучуудын боловсролын хандлага:** Дотоодын их сургуулиудын олон улсад өрсөлдөх чадвар, сургалтын чанар нь оюутан залуучуудын гадаадын их сургуулиудад сурах сонирхолд нөлөөлж байна.

4. Технологийн хүчин зүйл (Technological)

- **Дижитал шилжилт:** Дижитал технологи, цахим сургалтын хөгжил нь сургалтын чанар, хүртээмжид эерэг нөлөө үзүүлж байна. Гэвч зарим сургалтын байгууллагууд дижитал шилжилтийн хурдыг гүйцэхгүй байна.

- **Шинэ технологи нэвтрүүлэх:** Их сургуулиудын сургалтын чанар, инновацын төвүүдийн хүчин чадлыг сайжруулахад шинэ технологи нэвтрүүлэх шаардлагатай.

5. Байгаль орчны хүчин зүйл (Environmental)

- **Байгаль орчны бодлого:** Боловсролын салбарын байгаль орчны хариуцлагатай бодлого, ногоон технологи нэвтрүүлэх шаардлагатай байна.
- **Ус, эрчим хүчний хэрэглээ:** Сургалтын байгууллагуудын ус, эрчим хүчний хэрэглээг бууруулах, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг дэмжих шаардлагатай.

6. Хууль эрх зүйн хүчин зүйл (Legal)

- **Хууль эрх зүйн зохицуулалт:** Боловсролын хууль, дүрэм журам, стандартуудын шинэчлэл нь сургалтын чанар, багш нарын мэргэжлийн хөгжилд нөлөөлж байна.
- **Татвар, санхүүжилтийн бодлого:** Боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалтыг дэмжих хууль эрх зүйн орчин сайжрах шаардлагатай.

Дүгнэлт

МУИС болон бусад их дээд сургуулиудын үйл ажиллагаа нь макро орчны хүчин зүйлсийн нөлөөнд байнга өртөж, эдгээр хүчин зүйлсийн өөрчлөлт нь сургалтын чанар, хүртээмж, багш нарын мэргэжлийн хөгжилд нөлөөлж байна.

1.1.2 Микро Орчны Шинжилгээ (SWOT)

МУИС-ийн SWOT Шинжилгээ

Давуу тал (Strengths)

1. Судалгааны тэргүүлэгч:
 - МУИС нь ШУ-ны олон чиглэлээр судалгаа хийж, Web of Science, Scopus-д бүртгэлтэй эрдэм шинжилгээний өгүүллийн тоогоор улсдаа тэргүүлдэг.
 - Times Higher Education байгууллагын дэлхийн их сургуулиудын эрэмбэд 1500+, Азийн их сургуулиудын эрэмбэд 601+ байр эзэлсэн.
2. Багш, судлаачдын хүчирхэг баг:
 - Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, өндөр мэдлэгтэй багш, профессорын багтай.
 - Багш, суралцагсдын судалгаа, инновацын чадавхыг сайжруулах, мэдлэг, туршлагыг баяжуулах зорилго бүхий хүрээлэн, төвүүдтэй.
3. Багш, оюутны хөгжил
 - Багш, оюутны хөгжлийн төвтэй, дэмжих системтэй.
 - Оюутны хөгжлийн газар, хөгжлийн хөтөлбөртэй
4. Судалгаа, сургалт дэмжих систем:
 - Багш, оюутны судалгааны үйл ажиллагааг дэмжих зорилгоор өндөр түвшний залуу судлаачдын грант, зочин судлаачдын санхүүжилт зэрэг дэмжлэг үзүүлдэг.
5. Судалгааны лабораторийн сайжруулалт:
 - Лабораторийн талбай, нөхцөл сайжирсан, судалгааны орчныг сайжруулахад анхаарал хандуулж байна.
6. Брэндийн хүч:
 - Ууган, улсдаа тэргүүлэх их сургууль
 - Салбартаа манлайлсан төгсөгчдийн өргөн сүлжээ.
 - МУИС гэдэг брэндээрээ гадаад, дотоод харилцааг өргөжүүлэх нөөц боломжтой.

Сул тал (Weaknesses)

1. Улс төрөөс хараат байдал:
 - Бодлогын хэрэгжилт, стратегийн залгамж холбоо сул, улс төрийн нөлөөнд хэт хамааралтай.
2. Засаглалын тогтолцоо:

- Одоогийн засаглалын тогтолцоо нь үр ашгийг хангалттай дэмжихгүй, удирдлагын шийдвэр гаргалт удаан, эрх мэдлийн төвлөрөл ихтэй.
- 3. Сургалтын уян хатан байдал:
 - Сургалтын үйл ажиллагаа уян хатан бус, зах зээлтэй уялдуулан шинэчилж байгаа байдал сул.
- 4. Хүний Нөөц:
 - Ажилтны мэргэжлийн карьер хөгжлийн төлөвлөлт тодорхойгүй.
- 5. Гадаад, дотоод харилцаа:
 - Гадаад, дотоодын шилдэг багш нарыг зочин багшаар урьж ажиллуулах ажил хангалтгүй, гадаад оюутны тоо бага, хамтын ажиллагааны гэрээний эргэх холбоо сул.

Боломж (Opportunities)

1. Судалгаа:
 - Монгол улсын ДНБ-ий орлого нэмэгдэх төлөвтэй, төрийн дэмжлэг нэмэгдэж, судалгааны их сургуулийн статусыг бэхжүүлэх боломжтой.
2. Сургалт, хөтөлбөр:
 - Хос, хавсарга, хамтарсан хөтөлбөрийг сурталчлах, нэмэгдүүлэх боломжтой.
 - Цахим сургалтын техник, технологийн хөгжил эрс сайжирч, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх боломжтой.
 - Зэргийн бус сургалтын эрэлт хэрэгцээ ихсэж байна. (Бизнесийн байгууллагуудын ажиллах хүчнээ дахин сургалтад хамруулах, шинэ мэдлэг, ур чадвар эзэмших хэрэгцээ шаардлага улам өссөн).
3. Гадаад оюутан:
 - Олон улсын хамтарсан хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх, гадаад оюутны тоог нэмэгдүүлэх, гаднын их дээд сургуулиудаас бенчмарк хийх боломж. (БНХАУ-ын их сургууль чанаржсанаар БНСУ, Япон улсад сурдаг гадаад оюутны тоо эрс буурсан).
4. Хамтын ажиллагаа:
 - Төр, хувийн хэвшлийн хамтран ажиллах хүрээгээ өргөжүүлэх, донор байгууллагуудтай хамтран ажиллах боломж.

Аюул (Threats)

1. Брэндийн нэр хүнд:
 - МУИС-ийн институцийн орчин, өрсөлдөх чадвар буурах эрсдэлтэй.
2. Цалингийн өрсөлдөх чадвар:
 - Цалингийн өрсөлдөх чадвар буурснаар чадварлаг багш, мэргэжилтнүүдийг алдах эрсдэл.
3. Гадаадад суралцах урсгал:
 - Гадаадад сурах урсгал нэмэгдэж, шилдэг элсэгчдийг алдах эрсдэл.
4. Зах зээлийн хүлээлт ба бодит байдал:
 - Хөдөлмөрийн зах зээлд төгсөгчдийн хүлээлт ба бодит байдал зөрөх асуудал.

Дүгнэлт

МУИС нь Монголын дээд боловсролын салбарт тэргүүлэгч байр суурьтай боловч улс төрийн хараат байдал, засаглалын асуудал, сургалтын уян хатан бус байдал зэрэг сул талуудыг шийдвэрлэх шаардлагатай. Мөн хүнээ хөгжүүлэх бодлого, стратегид төвлөрөх, цахим сургалтын хөгжлийг ашиглан боломжуудаа нэмэгдүүлэх нь чухал юм.

Жилд нэг удаа Менежментийн дүн шинжилгээний хурлаар гадаад болон дотоод асуудлыг шинжлэн хэлэлцдэг.

Холбогдох баримт бичиг:

Гадаад болон дотоод асуудлын бүртгэл – (NUM/EOMS/FMT/14)

1.2 Сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг ойлгох

МУИС нь хууль, тогтоомжийн шаардлагын дагуу боловсролын үйлчилгээний тасралтгүй, тогтвортой байдлыг хангах үүднээс сонирхогч талууд болон сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлж, ангилдаг. Мөн менежментийн тогтолцоонд тавигдах шаардлагыг үр дүнтэй удирдаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд сонирхогч талуудын холбогдох хэрэгцээ, хүлээлтийг байнга хянаж, үнэлж, дүн шинжилгээ хийдэг.

1.2.1. МУИС-ийн сонирхогч талууд

Тус сургуулийн үйл ажиллагаа, хөгжлийн бодлого, шийдвэрээс шууд болон шууд бус байдлаар нөлөөнд өртдөг, эсвэл нөлөө үзүүлдэг хувь хүн, байгууллага, бүлэг МУИС-ийн сонирхогч тал болно. Эдгээрийг дотоод ба гадаад сонирхогч тал гэж ангилж үзэв.

А. Дотоод сонирхогч талууд:

- Дээд удирдлага
- Багш, судлаачид
- Ажилтнууд
- Суралцагчид
- Оюутны холбоо, клуб
- Үйлдвэрчний эвлэл

Б. Гадаад сонирхогч талууд:

- БЯ болон бусад холбогдох төрийн захиргааны байгууллагууд
- Хамтын ажиллагаатай гадаад, дотоодын их, дээд сургууль болон судалгааны байгууллагууд
- Боловсролын байгууллагууд /өрсөлдөгч/
- Гаднын үйлчилгээ нийлүүлэгчид
- Хэвлэл, мэдээллийн байгууллагууд
- Магадлан итгэмжлэлийн байгууллагууд
- Ажил олгогчид
- Зөвлөх, гэрээт, цагийн багш
- Ахмад багш, ажилтны холбоо
- Төгсөгчид, төгсөгчдийн холбоо
- Оюутан, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчид
- Нийгэм, олон нийт

1.2.2 МУИС-ийн сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлага

МУИС-ийн сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагыг дараах байдлаар тодорхойллоо.

Сонирхогч талууд	Хэрэгцээ, шаардлага
Дээд удирдлага	• Нэр хүнд, рейтинг өсгөх • Гүйцэтгэл, үр дүн • Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх • Чадварлаг хүний нөөцийг татаж ажиллуулах • Эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагааг өргөжүүлэх
Багш, судлаачид	• Ажиллахад тохиромжтой орчин нөхцөл, техник тоног төхөөрөмжөөр хангагдах • Гүйцэтгэлтэй уялдсан цалин, урамшуулал

	• Мэдлэг, туршлага, ур чадвараа дээшлүүлэх, судалгааны дэмжлэг • Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, академик эрх чөлөө эдлэх
Ажилтнууд	• Ажиллахад тохиромжтой орчин нөхцөл, техник тоног төхөөрөмжөөр хангагдах • Гүйцэтгэлтэй уялдсан цалин, урамшуулал • Хөгжих боломж, санхүүгийн дэмжлэг • Нийгмийн хангамж, баталгаагаар хангагдах
Суралцагчид	• Чанартай боловсрол, ур чадвар эзэмших • Мэдлэг, туршлага, ур чадвартай багшаар хичээл заалгах • Тав тухтай, хүртээмжтэй орчинд суралцах • Сургалтын тэтгэлэг, боломж • Төгсөөд мэргэжлээрээ ажилд ороход зуучлах, ажил олгогчидтой хамтарч ажиллах
Оюутны холбоо, клуб	• Суралцагчдын эрх ашгийг хамгаалах, идэвх оролцоог нэмэгдүүлэх
Үйлдвэрчний эвлэл	• Гишүүдийн (багш, ажилтан) эрх ашгийг хамгаалах
БШУЯ болон бусад холбогдох төрийн захиргааны байгууллагууд	• Хууль, стандарт, бодлогын хэрэгжилт • Шаардлагад нийцсэн хөтөлбөр, хөтөлбөрийн шинэчлэл
Хамтын ажиллагаатай гадаад, дотоодын их, дээд сургууль болон судалгааны байгууллагууд	• Туршлага солилцох, хамтран ажиллах • Гэрээний хэрэгжилт
Боловсролын байгууллагууд /өрсөлдөгч/	• Хамтарсан судалгаа, төсөл-хөтөлбөр хэрэгжүүлэх
Гаднын үйлчилгээ нийлүүлэгчид	• Бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ нийлүүлэх • Гэрээний хэрэгжилт
Хэвлэл, мэдээллийн байгууллагууд	• Үнэн зөв мэдээллийн эх сурвалж олж авах
Магадлан итгэмжлэлийн байгууллагууд	• Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг нэмэгдүүлэх • Хөтөлбөрийн сайжруулалт хийдэг байх
Ажил олгогчид	• Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар шаардлагад нийцдэг байх • Зөөлөн ур чадварыг хөгжүүлдэг байдал
Зөвлөх, гэрээт, цагийн багш	• Гэрээний хэрэгжилт
Ахмад багш, ажилтны холбоо	• Сургуулийн хөгжилд оролцох • Мэдлэг, туршлагаасаа өвлүүлэх, хичээл заах
Төгсөгчид, төгсөгчдийн холбоо	• Хамтран ажиллах, сургуулийн хөгжилд оролцох
Оюутан, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчид	• Чанартай боловсрол эзэмшүүлэх • Сургалтын орчин, нөхцөл сайн байх • Сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх
Нийгэм, олон нийт	• Нийгмийг соён гэгээрүүлэх, эрдэм мэдлэг түгээх, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах

Холбогдох баримт бичиг:

Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт- NUM/EOMS/FMT/15

1.3 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох

МУИС нь ISO 21001:2018 стандартад нийцсэн ББМТ-г нэвтрүүлэхдээ байгууллагын төлөв болон сонирхогч талуудын хэрэгцээг харгалзан, мөн боловсролын үйлчилгээний төрөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагааг үндэслэн хамрах хүрээг албан ёсоор тодорхойлсон болно.

Холбогдох баримт бичиг: ББМТ-ны хамрах хүрээ (Хавсралт-I)

МУИС-ийн менежментийн тогтолцоонд хамаарах байгууламжийн байршилд дараах зүйлс орно:

Газар	Байгууламжийн байршил	Баталгаажуулалтын хамрах хүрээ
Шинжлэх ухааны сургууль	Монгол улс, Улаанбаатар хот 210646, ш/х 377, Сүхбаатар дүүрэг, Залуучуудын өргөн чөлөө 1, Монгол Улсын Их сургууль хичээлийн II байр	Шинжлэх ухааны сургууль
Бизнесийн сургууль	Улаанбаатар хот, Их сургуулийн гудамж 1, Бага тойруу, Монгол Улсын Их сургууль хичээлийн IV байр	Бизнесийн сургууль
Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 1, МУИС-ийн хичээлийн V байр	Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль
Хууль зүйн сургууль	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж 17, Монгол Улсын Их Сургууль, Хичээлийн 3Б байр	Хууль зүйн сургууль
Мэдээллийн технологи, электроникийн сургууль	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Оюутны гудамж 14/3, МУИС-ийн 7, 8-р байр	Мэдээллийн технологи, электроникийн сургууль
Инженер, Технологийн сургууль	Их сургуулийн гудамж – 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, МУИС-ийн хичээлийн 1-р байр	Инженер, Технологийн сургууль
Оюутны I, II, III, IV, V, VI-р байр	Оюутны I байр – СБД-ийн 6-р хороо, Бага тойруу-47, хичээлийн 2-р байрны ард Оюутны II байр – СБД-ийн 6-р хороо, Бага тойруу-47, хичээлийн 2-р байрны ард Оюутны III байр – СБД-ийн 8-р хороо, оюутны 5-р байрны урд талд Оюутны IV байр – СБД-ийн 8-р хороо хуучнаар Дашчойлон хийдийн зүүн талд Оюутны V байр – СБД-ийн 8-р хороо, ЕБС-ийн 2-р дунд сургуулийн баруун талд Оюутны VI байр – СБД-ийн 8-р хороо хуучнаар ХҮДС-ийн оюутны байр	Оюутны I, II, III, IV, V, VI-р байр
Номын сан	Их Сургуулийн гудамж - 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Номын сан
Багш, оюутны хөгжлийн төв	Их сургуулийн гудамж - 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар.	Багш, оюутны хөгжлийн төв

1.4 ББМТ менежментийн тогтолцоо ба түүний үйл явц

МУИС нь ISO 21001:2018 стандартын шаардлагын дагуу Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоог (ББМТ) бий болгож, баримтжуулж, хэрэгжүүлж, засварлаж, үр дүнг нь тасралтгүй сайжруулдаг.


МУИС нь ББМТ-д шаардлагатай үндсэн үйл явц, тэдгээрийн дараалал, харилцан үйлчлэлийг тодорхойлж, хэрэглэдэг. Үүнд:

1. Үйл явцын тодорхойлолт: ББМТ-ны үйл явцуудыг стратегийн, сургалтын, судалгааны, дэмжих гэсэн үндсэн чиг үүргээр ангилсан (Хавсралт II - Дараалал ба Харилцан Үйлчлэл).
2. Үйл явцын удирдлага:
 - Үйл явцууд нь орц, гарц, шалгуур, арга зүй-г тодорхойлсон.
 - САЗ (Стандарт Үйл Ажиллагааны Журам) баримт бичгүүдтэй.
 - Үүрэг, эрх мэдлийг хуваарилж, мэдэгдсэн.
 - Үйл явц бүрийн эрсдэл, боломжуудыг тодорхойлж шийдвэрлэдэг.
3. Мониторинг ба сайжруулалт:
 - Үйл явцын гүйцэтгэлд мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ хийдэг.
 - Төлөвлөсөн үр дүнд хүрэх болон тогтолцоог тасралтгүй сайжруулах шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.
 - Байгууллагын хэмжээ, үйл ажиллагааны төрөл, үйл явцын нарийн төвөгтэй байдлыг харгалзан баримтжуулсан мэдээллийг (баримт бичиг, бүртгэл) хөтөлдөг.

Үндсэн үйл явцууд болон хариуцсан нэгжүүд:

Үйл явцын бүлэг	Хариуцсан нэгжүүд
Стратегийн менежмент	Ректорын зөвлөл, Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөл
Сургалт (Боловсролын үйлчилгээ)	Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газар, Оюутны хөгжлийн газар, Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих төв, бүрэлдэхүүн болон салбар сургуулиуд
Судалгаа	Судалгаа хөгжүүлэлтийн газар, Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих төв, бүрэлдэхүүн болон салбар сургуулиуд
Дэмжих үйл ажиллагаа	Захиргаа, хүний нөөцийн газар, санхүү бүртгэлийн газар, хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар, цахим шилжилтийн газар, номын сан, хангамж үйлчилгээний газар, ААТ нэгжүүд

ISO 21001 стандартын хүрээнд ББМТ

**Холбогдох баримт бичиг:**

Дараалал ба харилцан үйлчлэлийн график – (Хавсралт -II)

Баримт бичгийн мастер /үндсэн жагсаалт- (NUM/EOMS/FMT/09)

Бүртгэлийн нэгдсэн жагсаалт /үндсэн жагсаалт –(NUM/EOMS/FMT/11)

БҮЛЭГ 2: МАНЛАЙЛАЛ (ISO 21001:2018 стандарт, бүлэг 5)**2.1 Манлайлал ба амлалт****2.1.1. Ерөнхий зүйл**

МУИС-ийн Дээд удирдлага (Удирдах зөвлөл, Ректорын зөвлөл, Эрдмийн зөвлөл) болон менежментийн баг нь Боловсролын Байгууллагын Менежментийн Тогтолцоо (ББМТ)-г нэвтрүүлж, хэрэгжүүлж, тогтвортой үр дүнтэй хадгалж, тасралтгүй сайжруулах чиглэлээр тууштай байр суурь баримтлан, дараах үйл ажиллагаанд манлайлан оролцоно:

1. Их сургуулийн алсын хараа, эрхэм зорилго болон стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхийг дэмжинэ.
2. Стратегийн чиглэлийг тодорхойлж, төлөвлөж, хэрэгжүүлж, хянан үнэлж, тасралтгүй сайжруулна.
3. Бодлого, зорилтыг байгууллагын дотоод, гадаад орчны нөхцөл байдалд нийцүүлж бий болгоно.
4. Менежментийн тогтолцооны үр нөлөө, нийцлийг бүхэлд нь хариуцна.

5. Үр дүнтэй удирдлагын ач холбогдлыг таниулах, багш, ажилтан, суралцагчдын оролцоог дэмжинэ.
6. Эрсдэлд суурилсан сэтгэлгээ, үйл явцын хандлагыг хэрэгжүүлж, байгууллагын шийдвэр гаргалтад нэвтрүүлнэ.
7. ББМТ-д шаардагдах хүний нөөц, санхүү, орчин, дэд бүтэц, технологийн нөөцийг хангана.
8. ББМТ төлөвлөсөн үр дүнд хүрч буй эсэхийг хяналт-шинжилгээ, хэмжилт, дүн шинжилгээгээр баталгаажуулна.
9. Тасралтгүй сайжруулалтыг дэмжиж, урамшуулна.
10. Суралцагч, үйлчлүүлэгч болон бусад сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагад төвлөрч ажиллана.
11. Нийгмийн өмнө хариуцлагатайгаар боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлнэ.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн эрхэм зорилго, алсын хараа
- МУИС-ийн стратегийн төлөвлөгөө
- Удирдах зөвлөлийн дүрэм
- Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журам
- Суралцагч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа

2.1.2. Суралцагч болон бусад үйлчлүүлэгчдэд төвлөрч ажиллана:

МУИС-ийн дээд удирдлага нь суралцагч болон бусад сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг баталгаажуулна. Энэ хүрээнд:

- Холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг тодорхойлж, хангаж ажиллана.
- Суралцагч, үйлчлүүлэгчдийн өргөдөл, санал, гомдлыг нээлттэйгээр хүлээн авч, шударгаар шийдвэрлэнэ.
- Хэрэгцээ, хүлээлтийг тогтмол тодорхойлж, сэтгэл ханамжийн судалгаа, хяналт-шинжилгээгээр баталгаажуулна.
- Сургалт, судалгааны үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, боломжийг үнэлж, сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.

2.1.3. Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага

МУИС-ийн удирдлага нь тусгай хэрэгцээт суралцагчдад боловсрол олгоход дараах нэмэлт шаардлагыг хангана. Үүнд:

- Тусгай хэрэгцээт суралцагчдад хэрэгцээт мэдээллийг төвөггүй хүлээн авах харилцаа холбооны сувгийг бий болгож, хадгална.
- Байгууллагын нөөц болон суралцах орчныг тусгай хэрэгцээт суралцагчдад бусад суралцагчидтай адил түвшинд хангалттай тэгш, хүртээмжтэй байхаар зохион байгуулна.

Холбогдох баримт бичиг:

- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан үйлчилгээг үзүүлэх бодлого
- Орчны хүртээмж, дасан зохицох үнэлгээний тайлан
- Харилцаа холбооны тусгай сувгуудын тайлбар, дүрэм
- Нийгмийн хариуцлагын тайлан

2.2. Бодлого

2.2.1. Бодлого боловсруулах

МУИС-ийн дээд удирдлага нь боловсролын байгууллагын бодлогыг (Хавсралт-III) бий болгож, хэрэгжүүлж, дүн шинжилгээ хийж, тасралтгүй сайжруулна. Тус бодлого нь:

- Боловсролын байгууллагын эрхэм зорилго, алсын харааг дэмжсэн;
- Байгууллагын зорилго, нөхцөл байдалд тохирсон;
- Зорилтуудыг тодорхойлох тогтолцоог бүрдүүлсэн;

- Хууль, зохицуулалт болон сонирхогч талуудын шаардлагыг тусгасан;
- Менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулах амлалтыг багтаасан;
- Боловсрол, шинжлэх ухаан, техникийн холбогдох хөгжилд нийцүүлсэн;
- Байгууллагын нийгмийн хариуцлагыг биелүүлэх үүрэг, амлалтыг тусгасан;
- Оюуны өмчийг удирдах амлалтыг тайлбарлаж, тусгасан;
- Холбогдох сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг харгалзан үзсэн байна.

2.2.2. Бодлогыг мэдээлэх

ББМТ-ны бодлогыг баримтжуулсан мэдээлэл болгон хадгалдаг ба байгууллагын хэмжээнд ил тод мэдээлж ойлгуулах, сонирхогч талуудад нээлттэй, хүртээмжтэй байлгана.

Мэдээлэх суваг нь МУИС-ийн вэб сайт, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн вэб сайт, сэтгүүл, каталог, мэдээллийн самбар гэх мэт байна.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны бодлого (Хавсралт-III)

2.3. Байгууллага дахь үүрэг, хариуцлага, эрх мэдэл

МУИС-ийн удирдлага нь бүрэлдэхүүн ба салбар сургууль, удирдлага, бодлого, үйлчилгээ, сургалт, судалгааны болон бие даасан нэгж, харьяа байгууллага зэрэг зохион байгуулалтын бүтэцтэйгээр ажилладаг. Дээд удирдлага нь холбогдох нэгж, албан тушаалтны чиг үүрэгт хамаарах хариуцлага, эрх мэдлийг тодорхойлж, ажил үүргийн тодорхойлолт болон тогтоол, тушаал, журам, шийдвэрээр хуваарилдаг. Энэ нь:

- ISO 21001 стандартын шаардлагад тохирч байгааг баталсан;
- Байгууллагын ББМТ-ны бодлогыг ойлгож, хэрэгжүүлсэн эсэхийг баталгаажуулах;
- Боловсролын менежментийн тогтолцооны үйл явц нь төлөвлөсөн үр дүнд хүрэхийг баталгаажуулсан;
- Менежментийн тогтолцооны гүйцэтгэл, сайжруулах боломжуудын талаар дээд удирдлагад тайлагнасан;
- Байгууллага даяар суралцагчид болон бусад үйлчлүүлэгчдэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн;
- Менежментийн тогтолцоонд өөрчлөлт оруулах, түүний бүрэн бүтэн байдлыг хангасан;
- Байгууллагын харилцаа холбоог удирдсан;
- Сургалтын бүх үйл явцыг сургалтын хэлбэрээс үл хамааран нэгдмэл байлгасан;
- Баримтжуулсан мэдээллийг хянасан;
- Тусгай хэрэгцээт суралцагчдын шаардлагын хэрэгжилтийг удирдсан байна.

Холбогдох баримт бичиг:

- Байгууллагын бүтцийн диаграмм (Хавсралт-IV)
- Ажил үүргийн тодорхойлолт (удирдах, гүйцэтгэх түвшний)
- Ажил, үүрэг хариуцлагын хуваарилалтын тогтоол, тушаал
- Гүйцэтгэлийн үнэлгээний журам, маягт, тайлан
- Хүний нөөцийн журам (сургалт, хөгжил, ёс зүй, томилгоо)
- МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм
- МУИС-д профессор багш ажиллуулах журам
- МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам
- МУИС-ийн удирдах болон гүйцэтгэх ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, аргачлал
- МУИС-ийн гүйцэтгэх ажилтны нэгдсэн үнэлгээ (аттестатчилал)-ын журам
- МУИС-д ажилтан ажиллуулах журам
- МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааны журам
- МУИС-ийн багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журам

- Зөвшөөрлийн мэдэгдэл (Хавсралт-V)

БҮЛЭГ 3: ТӨЛӨВЛӨЛТ (ISO 21001 стандарт, бүлэг 6)

3.1. Эрсдэл ба боломжид чиглэсэн арга хэмжээ

МУИС тодорхойлсон гадаад болон дотоод асуудлууд, сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт тэдгээрт хамаарах шаардлагатай эрсдэл, боломжуудыг тодорхойлох үйл явцтай. Энэ үйл явц нь:

- Менежментийн тогтолцоо нь төлөвлөсөн үр дүндээ хүрч чадна гэдгийг баталгаажуулах;
- Хүссэн эерэг нөлөөг дэмжих, сайжруулах;
- Хүсээгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, багасгах;
- Байнгын сайжруулалтыг хангахад чиглэнэ.

Эрсдэлийн менежментийг байгууллагын стратегиас эхлээд үйл ажиллагааны бүх түвшинд хэрэгжүүлдэг. Эрсдэлийн үнэлгээний үр дүнг үйл явцын үйл ажиллагаа, эрсдэлийг хянах төлөвлөгөөг баримтжуулахад харгалзан үздэг.

Үйл явц бүрийн эрсдэл, боломжийг “Эрсдэл ба боломжийн менежментийн журам”-ын дагуу эрсдэлийн үнэлгээний бүртгэлд тодорхойлж, тусгадаг. (NUM/EOMS/PRO/007)

Эрсдэл, боломжуудыг шийдвэрлэхийн тулд авч буй арга хэмжээ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний тохиролд үзүүлэх нөлөөлөл болон үүсэх магадлалтай пропорциональ байна. Байгууллага доторх эрсдэл, боломжийн менежментийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг харгалзан эрсдэлийг арилгах төлөвлөгөө, боломжийн менежментийн төлөвлөгөөг зохих ёсоор төлөвлөж хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн үнэлгээний бүртгэлийг жилд нэгээс доошгүй удаа хянаж, шаардлагатай бол шинэчилдэг.

Холбогдох баримт бичиг:

Эрсдэлийн менежментийн журам (NUM/EOMS/PRO/007)

Эрсдэлийн үнэлгээний бүртгэл

Боломжийн менежментийн төлөвлөгөө

3.2. Боловсролын байгууллагын зорилт, тэдгээрт хүрэх төлөвлөлт

МУИС нь менежментийн тогтолцоонд шаардлагатай холбогдох чиг үүрэг, түвшин, үйл явц дахь зорилгыг тогтоож, тогтоож, зорилтуудын төлөвлөгөөнд баримтжуулдаг.

Боловсролын байгууллагын зорилт нь:

- Боловсролын байгууллагын бодлогод нийцсэн;
- Хэмжих боломжтой (боломжтой бол);
- Холбогдох шаардлагыг харгалзсан;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын байдал, суралцагч, ажилтнууд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхтэй холбоотой;
- Байнгын мониторинг явуулдаг байх;
- Харилцаа холбоонд нийцтэй;
- Шинэчлэхэд тохиромжтой байна.

Үйл явцын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд (KPI) нь тухайн үйл явцын гарын авлагад тодорхойлогдсон бөгөөд байгууллагын зорилго, стратеги төлөвлөгөөнд хүрэхийн тулд үйл явцын гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор мониторинг явуулдаг.

Зорилгодоо хүрэх төлөвлөгөөг мөн тодорхойлж, баримтжуулсан бөгөөд үүнд:

- Юу хийх
- Ямар эх үүсвэр шаардагдах
- Хэн хариуцах
- Хэзээ дуусгах

- Үр дүнг хэрхэн үнэлэхийг тусгасан болно.

Үйл явцын түвшинд тогтмол мониторинг хийдэг бөгөөд гүйцэтгэлийн байдлыг удирдлагын дүн шинжилгээний хурлын үеэр тайлагнана.

Холбогдох баримт бичиг:

Монгол улсын их сургууль /МУИС/ стратеги төлөвлөгөө

Зорилтуудын төлөвлөгөө- Хавсралт -XXXIV

3.3. Өөрчлөлтийг төлөвлөх

МУИС менежментийн тогтолцоонд өөрчлөлт оруулах хэрэгцээг тодорхойлсон тохиолдолд “Өөрчлөлтийн менежментийн журам”-ын дагуу (NUM/EOMS/PRO/006) төлөвлөгөөт байдлаар хийнэ. Өөрчлөлт бүрийн хувьд

- Өөрчлөлтийн зорилго, тэдгээрийн болзошгүй үр дагавар;
- ББМТ-ны бүрэн бүтэн байдал;
- Дотоод нөөцийн бэлэн байдал;
- Үүрэг, эрх мэдлийг хуваарилах буюу дахин хуваарилах;
- Өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гаднын үйлчилгээ үзүүлэгчдийн бэлэн байдлыг авч үзнэ.

Өөрчлөлтүүдийг төлөвлөсөн журмын дагуу төлөвлөж, хэрэгжүүлж, үр дүнтэй эсэхийг магадлан шалгадаг.

Холбогдох баримт бичиг:

Өөрчлөлтийн менежментийн журам (NUM/EOMS/PRO/006)

БҮЛЭГ 4: ТУЛГУУР ХҮЧИН ЗҮЙЛ (ISO 21001:2018 стандарт, бүлэг 7)

4.1 Ерөнхий зүйл

МУИС нь үйл ажиллагаандаа ББМТ-г хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай бүх нөөцийг тодорхойлж, түүнийг ханган ажиллана. Нөөцийг:

- **Дотоод нөөц:** өөрийн хүний нөөц, сургалтын дэд бүтэц, санхүүгийн эх үүсвэр, байгууллагын мэдлэг;
- **Гадаад нөөц:** төрийн санхүүжилт, хамтарсан хөтөлбөр, төслийн эх үүсвэр, зочин багш, судлаач, тэтгэлэг, гадаад үйлчилгээ үзүүлэгчид (цахилгаан, дулаан, засвар үйлчилгээ, бараа материалын худалдан авалт) хэмээн хоёр ангилан тодорхойлно.

Тасралтгүй хэвийн үйл ажиллагааг явуулахын тулд өөрийн дотоод нөөцийг бүрэн ашиглаж шаардлагатай тохиолдолд гадаад нөөцийг ашиглаж, хянаж ажиллах ба дараах байдлаар тодорхойлж, хангадаг бөгөөд ингэснээр тэдгээрийг тогтвортой сайжруулдаг.

Дотоод нөөц	Гадаад нөөц
• Хүний нөөц: Чадварлаг, туршлагатай ажилтан, багш нар.	• Санхүүжилт: Төрийн санхүүжилт, төсөл, гэрээт ажлууд, тэтгэлэг.
• Дэд бүтэц: Барилга байгууламж, лаборатори, тоног төхөөрөмж.	• Мэргэжилтэн: Ахмад болон гэрээт, зочин багш/судлаачид.
• Технологи: Программ хангамж, техник хангамж, номын сан.	• Үйлчилгээ: Цахилгаан, дулаан хангамж, засвар үйлчилгээ.
• Санхүүгийн нөөц: Байгууллагын өөрийн санхүүжилт.	• Худалдан авалт: Бараа материалын худалдан авалт.
• Байгууллагын мэдлэг: Мэдээллийн эх үүсвэр, туршлага.	

МУИС нь нөөцийн хангалтыг дараах зарчмаар хэрэгжүүлдэг:

- Суралцах чадварыг сайжруулж, сургалтын үр дүнд хүрэхэд түлхэц өгөх үйл ажиллагаануудаар дамжуулан суралцагчийн оролцоо, сэтгэл ханамжийг дээшлүүлэх;
- Суралцах ажлыг хөнгөвчлөхийн тулд ажилтнуудын ур чадварыг сайжруулах үйл ажиллагаагаар дамжуулан ажилтнуудын оролцоо, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх;
- Суралцах нь нийгмийн үр өгөөжид хувь нэмэр оруулах үйл ажиллагаагаар дамжуулан бусад үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулах.

МУИС нь дараах эх үүсвэрээс ямар нөөцөөр хангахыг тодорхойлж, хяналт тавьдаг.

- Байгууллага;
- Гадаад үйлчилгээ үзүүлэгчид.

Байгууллага нь тусгай хэрэгцээтэй суралцагчдын хэрэгцээг харгалзан үзэж, олон төрлийн хүртээмжтэй байх шаардлагыг урьдчилан тооцдог. Одоо байгаа дотоод нөөцийн боломж, хязгаарлалтыг харгалзан нөөцийг хуваарилдаг. Нөөц ба түүний хуваарилалтыг удирдлагын дүн шинжилгээний явцад үнэлдэг.

4.2 Хүний нөөц

МУИС нь алсын хараа, эрхэм зорилго, стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадамжтай чадварлаг ажилтнуудыг нээлттэй, ил тод сонгон шалгаруулалт явуулж бүрдүүлнэ. Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой бүх асуудлыг "Хүний Нөөцийн Үйл Явцын Гарын авлага" (Хавсралт-VIII) болон холбогдох журмын дагуу зохицуулна. Нөөцийн Бүрэлдэхүүн:

а) Байгууллагын үндсэн ажилтнууд:

- МУИС нь нийт 1605 (2024 оны байдлаар) багш, ажилтантай бөгөөд 120 гаруй албан тушаалын зэрэглэл, ангилалтай.
- Ажлын байр бүр нь тавигдах шаардлага, чадамжийн шалгууртай байна.
- Ажлын байрны тодорхойлолтыг Ректорын тушаалаар баталгаажуулж, ажилтныг сонгон шалгаруулахад мөрдөнө (Жишээ нь: Ректорын 2024 оны Б/515 дугаар тушаал).

б) Сайн дурын болон дадлагын ажилтнууд:

- МУИС нь суралцагчдад цагийн ажил хийх боломжийг олгодог бөгөөд тэдний хөдөлмөр эрхлэх харилцааг холбогдох тушаалаар (Жишээ нь: Захирлын А/143 дугаар тушаал) зохицуулна. (2024-2025 онд нийт 258 оюутан хөдөлмөр эрхэлсэн).

в) Гаднын ажилтан (Гэрээт ажилтан):

- Зөвлөх, гэрээт, зочин профессор, дэд профессор, цагийн багш нарыг сургалт, судалгааны хэрэгцээг үндэслэн холбогдох журмын дагуу гэрээгээр ажиллуулдаг. (Жишээ нь: 2024-2025 онд нийт 387 багш гэрээгээр ажилласан).
- Зохицуулалт: Тэднийг ажиллуулах харилцааг "МУИС-д зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам"-аар зохицуулдаг.

Холбогдох баримт бичиг:

Байгууллагын бүтцийн диаграмм (Хавсралт-IV)

Үйл явцын гарын авлага - Хүний нөөц (NUM/EOMS/PFC/009) Хавсралт -VIII

Хөдөлмөрийн дотоод журам,

Зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам,

Эрдэм шинжилгээний ажилтан ажиллуулах журам

Пост-доктор ажиллуулах журам

Магистрант докторантыг туслахаар ажиллуулах журам

МУИС-ийн ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам

Хүндэт цол олгох журам

Шагнал урамшууллын нийтлэг журам

МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам

4.3 Байгууламж

МУИС нь “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.1 дэх зорилтын 2.1.12-т “Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ” гэж заасны дагуу 2025-2030 оны Стратеги төлөвлөгөө (Хавсралт 1.1)-ний 4.2-т “Сурах, ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх” зорилгыг дэвшүүлсэн бөгөөд МУИС нь 2024-2025 оны хичээлийн жилийн байдлаар бүрэлдэхүүн 8 сургууль, салбар 3 сургууль, харьяа 2 сургууль, бие даасан 8 нэгжтэй 1600 багш, ажилтан, 23604 суралцагчтайгаар сургалт, судалгааны үйл ажиллагаа эрхэлж байна.

Байгууллага сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулахдаа нийт багш, суралцагч, ажилтнуудын сурах, ажиллах таатай орчныг бүрдүүлэхийн тулд холбогдох стандартад нийцсэн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж, дэд бүтцийг сайжруулж ханган ажиллана. Хөрөнгийн менежментийн арга зүйг хэрэглэж үйл явцын гарын авлагын дагуу, хөрөнгийн шинжилгээ, засвар үйлчилгээ, найдвартай ажиллагааг тогтмол хангана.

МУИС-ийн байгууламж:

1. Барилга байгууламж, тоног төхөөрөмж,
2. Лаборатори, дадлагын бааз,
3. Программ хангамж, техник хангамж,
4. Номын сан, сургалтын материал
5. Оюутны дотуур байр

Холбогдох баримт бичиг

- МУИС-ийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам
- Оюутны дотуур байрны журам
- Номын сангийн журам
- ТҮЦ машиныг ашиглах журам
- Судалгааны лаборатори ажиллуулах журам
- МУИС-ийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам
- МУИС-ийн эзэмшлийн авто тээврийн хэрэгслийг ашиглаж журам
- Хурлын танхим ашиглалтын журам, гэрээ
- Аж ахуй, эд хөрөнгө үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/007) Хавсралт-XV
- Мэдээллийн технологийн үйл явцын гарын авлага (IT) (NUM/EOMS/PFC/010) Хавсралт-XVII
- Кампусын / Их сургуулийн хотхоны / үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/005) Хавсралт-XIII

Хичээлийн байр:

Монгол Улсын их сургуулийн бүрэлдэхүүн болон салбар сургуулийн барилга байгууламжийг зориулалтаар нь ангилбал:

- Хичээл, сургалтын зориулалттай барилга
- Оюутны дотуур байрны барилга
- Сургалт судалгаа болон дадлагын баазын зориулалт бүхий барилга
- Орон сууцны барилга
- Бусад барилга гэсэн төрлүүдэд ангилагдаж байна.

Хичээл, сургалтын зориулалттай барилгын 13 нь хичээлийн байр, 2 барилга шинэ номын сан, багш, оюутны хөгжлийн төвийн барилга байна.

Хичээлийн барилгын ашигласан жил, насжилтыг авч үзвэл үндсэн барилгууд нь 41-82 жилийн насжилттай, өргөтгөлийн хэсгийн барилга 12-26 жилийн насжилттай байна.

1. Хичээлийн 1 дүгээр байр нь хамгийн олон буюу 82 жилийн насжилттай, барилгыг НИТХ-ын 2021 оны 12/35 дугаар тогтоолоор дүүргийн хамгаалалтад авсан;
2. Хичээлийн 2 дугаар байранд 1974 онд өргөтгөл хийгдсэн, 63 жилийн насжилттай,

3. Хичээлийн 3 дугаар байрыг 2023 онд акталж буулгасан;
4. Хичээлийн 4 дүгээр байр нь 66 жилийн насжилттай;
5. Хичээлийн 5 дугаар байр нь хамгийн залуу буюу 19 жилийн насжилттай;
6. Хичээлийн 6 дугаар байрыг 2017 онд акталж буулгасан;
7. Хичээлийн 7, 8 дугаар байрууд нь хуучнаар Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулиас шилжин ирсэн, 40 жилийн насжилттай;
8. Хичээлийн 9 дүгээр байр Улаанбаатар их сургуулиас шилжин ирсэн, 41 жилийн насжилттай;
9. Орон нутаг дах 3 сургуулийн барилга 41-52 жилийн насжилттай, өргөтгөл, засвар хийгдээгүй;
10. Байгаль эх лицей ахлах сургуулийн барилга нь 2012 онд өргөтгөл хийгдсэн ба 40 жилийн насжилттай байна.

Оюутны байр:

МУИС нь Улаанбаатар хотод оюутны 6 байртай. Оюутны байрууд нь 1962-1987 оны хооронд ашиглалтад орсон, 34-62 жил ашиглагдсан ба 2018 онд үл хөдлөх хөрөнгөд хийсэн дахин үнэлгээгээр цаашид ашиглах хугацааг 19-37 жилээр шинэчлэн тогтоосон байна.

№	Барилгын нэр	Барилгын ашиглалтад орсон огноо	Газрын гэрчилгээний дугаар	Газрын хэмжээ м.кв	Давхарын тоо	Барилгын хэмжээс					
						Суурийн талбай, м.кв	Нийт талбай, м.кв (тэнхлэгээр)	Ашигтай талбай, м.кв	Нийтийн эзэмшил /м2/	Өрөөний тоо /ш/	Давхарын өндөр, м
1	Оюутны 1-р байр	1962	65624	895	4	850	2741.7	1776.3	965.4	116	12
2	Оюутны 2-р байр	1963	65611	879	4	850	2741.7	1776.3	965.4	121	12
3	Оюутны 3-р байр	1983	178543	865	4	784.1	2363.2	1642.1	721.1	119	12.2
4	Оюутны 4-р байр	1987	065/626		2,4	1174.32	4172.3	1779.9	2392.4	120	8-16
5	Оюутны 5-р байр	1990	65625	890	4	935	3138	1960.7	1177.3	123	12
6	Оюутны 6-р байр	1978	54554	14500	4	850	2741.7	1776.3	965.4	116	12

Сургалт судалгаа, дадлагын баазын зориулалттай барилгын талаар: МУИС-ийн сургалт, судалгаа, дадлагын баазын зориулалтаар ашиглаж байгаа 23 бааз байна. Сургалт дадлагын баазууд нь Улаанбаатар хотоос алслагдмал байршдаг бөгөөд зуны улиралд оюутан сурагчдыг дадлагажуулах, гаднын оюутан, эрдэмтэн судлаачдаас туршлага судлах, хамтран ажиллах зорилгоор байгуулсан байна.

4.3.1 Боловсролын үйл явцыг хэрэгжүүлэх орчин

Сургуулийн захиргаа нь нийт суралцагч, багш ажилтнуудаа эрүүл, аюулгүй орчинд сургалт, судалгааны хэвийн тасралтгүй үйл ажиллагааг явуулах боломжоор хангана.

- Хяналт ба хариуцлага: Анги танхим, лаборатори, тоног төхөөрөмжүүдийн шаардлагад нийцсэн байдлыг тогтмол шалгаж, сайжруулах арга хэмжээг тухайн салбар сургууль, холбогдох нэгжүүд хариуцна.
- Инженерийн дэд бүтэц: Барилга байгууламжийн халаалт, агааржуулалт, гэрэлтүүлэг, цахилгаан хангамж зэрэг инженерийн шугам сүлжээний хэвийн байдлыг дотоодын нөөцөд тулгуурлан тогтмол хангана. (Жишээ нь: Халаалтын улиралд 24 цагийн хяналт тавьж ажилладаг).

- Сэтгэл Зүйн Орчин: Суралцагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээг тогтмол үзүүлдэг. (Жишээ нь: 2023-2024 онд 169 суралцагчид 261 цагийн зөвлөгөө өгсөн).

Сургалтын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдээллээр хангах, процессыг зураглал, баримтлах дүрэм журмууд ил тод байна.

Холбогдох баримт бичиг

МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам

Бакалаврын өдрийн хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилийн намрын улиралд оюутан элсүүлэх журам

МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам

МУИС-ийн Магистр, докторын хөтөлбөрт оюутан элсүүлэх журам

МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журам

МУИС-ийн Номын сангийн журам

МУИС-ийн оюутны дотуур байрны журам

МУИС-ийн оюутанд тэтгэлэг олгох ерөнхий журам

Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журам

Суралцагч шилжүүлэн суралцуулах журам

Суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам

Багш нарын ажлын байран дээрээ хөгжих боломжийг нэмэгдүүлж МУИС-ийн Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих төв багш нарыг сургалт, судалгаа, хувь хүний цогц чадамжийн хүрээнд хөгжүүлэх хөтөлбөр, сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг. Багш ажилтнууд ажлын байран дээрээ хөгжих боломжийг олгож тодорхой санхүүжилтийг жил бүр төсөвт суулгадаг.

Багш, ажилтнуудыг ажлын гүйцэтгэлд тулгуурлан шагнаж урамшуулах, багш нар зэрэглэл ахих, цол олгох үйл ажиллагаа нь журмын хүрээнд тодорхойлогдсон байдаг.

Холбогдох баримт бичиг

МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр

МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам

МУИС-ийн профессор, дэд профессор цол олгох журам


Шагнал урамшууллын нийтлэг журам

Багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журам


МУИС-ийн удирдах болон гүйцэтгэх ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, аргачлал батлах тухай

МУИС-ийн ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам

Бакалаврын өдрийн хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилийн намрын



Зураг. Сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээнд хамрагдсан суралцагчдын тоо болон ганцаарчилсан зөвлөгөө өгсөн цаг



Зураг. 2023-2024 оны хичээлийн жилд сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдсан суралцагчдын үзүүлэлт

Багш, ажилтнуудын сэтгэл зүйн орчны байдлыг тодорхойлж, ажлын үр бүтээлтэй холбон судлах нь хүний нөөцийн бодлогын зайлшгүй нэг хэсэг байна.

4.4. Нөөцийн мониторинг, хэмжилт

Ерөнхий зүйл

МУИС нь ББМТ-ны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, шалгах, мониторинг хийхэд шаардлагатай нөөц, тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслүүдийг тодорхойлж, шаардлагын дагуу тохируулга, баталгаажуулалт хийж, хяналт тавина.

Энэ нөөцөд сургалт, эрдэм шинжилгээний үнэлгээний арга хэрэгсэл, шалгалт, тестийн аргачлал, сургалт, эрдэм шинжилгээний программ хангамж зэргийг хамааруулах ба эдгээр нь үйл ажиллагааны онцлогт тохирсон, зохих шаардлагыг хангасан байна.

МУИС нь үйлчилгээний тохирлыг баталгаажуулах мониторинг, хэмжилтийн үйл ажиллагааны хүчинтэй, найдвартай үр дүнд шаардагдах хангалттай нөөцийг тодорхойлж, хангадаг.

Байгууллага нь олгосон нөөцийг баталгаажуулсан.

- Хийж буй мониторинг, хэмжилтийн үйл ажиллагааны тодорхой төрөлд тохирсон, тухайлбал боловсролын үйлчилгээний зорилго, төрөл, арга хэлбэр, үргэлжлэх хугацаанд тохирсон байх;
- Гүйцэтгэлийг хэмжих, багш, ажилтнуудыг тогтмол сургах, хөгжүүлэх замаар зорилгодоо нийцүүлэн ажиллахад нь анхаардаг.

Байгууллага нь мониторинг, хэмжилтийн нөөцөд нийцэж буйг нотлох баримт болгон зохих баримтжуулсан мэдээллийг хадгалдаг.

Хэмжилтийг мөшгөх боломж

Хэмжилтийн үл мөрийг мөрдөх шаардлага буюу байгууллага хэмжилтийн үр дүнгийн үнэн зөвд итгэх итгэлийг хангах чухал хэсэг гэж үзвэл хэмжилтийн нөөц нь:

- Олон улсын болон үндэсний хэмжилтийн стандартыг дагаж мөрдөж болох хэмжилтийн стандартын дагуу тогтоосон давтамжаар, эсхүл хэрэглэхийн өмнө хоёуланг нь баталгаажуулсан эсвэл тохируулсан; ийм стандарт байхгүй тохиолдолд шалгалт тохируулга, баталгаажуулалтад ашигласан үндэслэлийг баримтжуулсан мэдээлэл болгон хадгална;
- Тэдний төлөв байдлыг тодорхойлсон;
- Шалгалт тохируулгын байдал болон дараачийн хэмжилтийн үр дүнг хүчингүй болгох тохируулга, гэмтэл, муудахаас хамгаалсан.

МУИС нь хэмжилтийн тоног төхөөрөмж зориулалтын дагуу тохиромжгүй болох нь тогтоогдвол өмнөх хэмжилтийн үр дүнгийн хүчин төгөлдөр байдалд сөргөөр нөлөөлсөн эсэхийг тодорхойлж, шаардлагатай бол зохих арга хэмжээг авна.

4.5. Байгууллагын мэдлэг

МУИС-ийн үйл ажиллагааны гол тулгуур нь байгууллага дах мэдлэг, инновац, оюуны өмч юм. Эдгээр МУИС-д бүтээгдэж байгаа мэдлэг нь байгууллагын эрхэм зорилго, алсын хараа хүрэхэд хэрэглэгдэнэ.

Байгууллагын мэдлэг нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- **Дотоод:** Судалгааны үр дүн, эрдэм шинжилгээний бүтээл, ажилтнуудын туршлага (Зөвлөх профессорууд), шинэлэг санаа, шилдэг туршлагауд.
- **Гадаад:** Олон улсын сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагаа, мэргэжлийн хурлуудаас олж авсан мэдээлэл.

Мэдлэгийн менежментийн арга зүйг хэрэглэж, дараах үйл явцын дагуу мэдлэгийг бүтээнэ:

Дотоод эх сурвалжууд	Гадаад эх сурвалжууд
+ Бодлогын баримт бичиг	+ Үндэсний, Олон улсын стандарт
+ Дотоод дүрэм, журам	+ Олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинар
+ Сургалтын хөтөлбөр	+ Хамтарсан төсөл хөтөлбөр
+ Хичээл, сургалт, шалгалтын материал, хэрэглэгдэхүүн	+ Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг
+ Ном, сурах бичиг, гарын авлага	+ Туршлага солилцох хөтөлбөр
+ Лаборатори, дадлагын ажлын тайлан	+ Хурал, уулзалт,
+ Эрдэм шинжилгээний өгүүлэл, сэтгүүл	+ Гадаад улсын төсөл, хөтөлбөр
+ Төгсөгчдийн судалгааны бүтээл	
+ Баримт бичгийн эмхэтгэл	
+ Оюуны өмч, патент, ашигтай загвар	
+ Гэрээт төсөл, хөтөлбөр	
+ Аливаа тайлан, мэдээ	
+ Бодлогын баримт бичиг	

Холбогдох баримт бичиг

Хамтын ажиллагааны гэрээ байгуулах тухай журам,
Оюуны өмчийн талаар баримтлах бодлого,
Технологи дамжуулах журам
Албан хэрэг хөтлөлтийн журам
Магистр докторын судалгааны ажлын үр дүнг хүлээлгэн өгөх журам
МУИС-ийн санхүүжилтээр сурах бичиг зохиох, орчуулах үйл ажиллагааг зохицуулах журам
Эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн хэвлүүлэхэд баримтлах журам

Монгол Улсын Их Сургуулийн байгууллагын мэдлэгт үр дүнтэй ажиллагаа, стратеги хөгжлийг хангахын тулд сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээний үнэ цэнийг хадгалж буй бүх мэдлэг юм. МУИС-ийн байгууллагын мэдлэгт дараах төрлийн мэдээллүүд багтана. Үүнд:

- **Байгууллагын зорилго, алсын хараа:** МУИС-ийн эрхэм зорилго, үнэт зүйл, урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө.
- **Удирдлагын бодлого, холбогдох дүрэм журам:** Засаглалын үйл ажиллагааг ил тод, хариуцлагатай байлгахад чиглэсэн МУИС-ийн удирдлагын бүтэц, үйл ажиллагааны журам, шийдвэр гаргах процессын зураглал, бүх түвшний дүрэм, журам.
- **Бүх шатны сургалтын хөтөлбөр:** Олон улсын түвшинд нийцсэн бакалавр, магистр, докторын түвшний сургалтын хөтөлбөрийн иж бүрэн баримт бичиг, хөтөлбөрийн бүтэц, хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, боловсролын талаар баримталж буй бодлого.
- **Оюутны асуудал:** Оюутны элсэлт, үйлчилгээ (сургалтын болон амьдрах орчин), сургалтын үйл ажиллагаа, оюутан солилцоо, танхимаас гадуурх үйл ажиллагаа, эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль эрх зүй, ажил мэргэжил, карьер хөгжлийн зөвлөгөө.
- **Эрдэм шинжилгээ, судалгаа, инновац:** Судалгааны чиглэл, төсөл хөтөлбөр, тэдгээрийн санхүүжилт, дотоод, гадаад хамтын ажиллагаа. Судалгааны лаборатори, судалгаа, инновацын төвүүд
- **Багш, ажилтнуудын мэдээлэл:** Багш ажилтны мэргэжлийн ур чадвар, багш ажилтны үүрэг, багш ажилтны хөгжлийн хөтөлбөр, хүний нөөцийн бодлого. Багш, ажилтан солилцоо, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо

- **Хамтран ажиллах байгууллагууд, түншлэл:** Засгийн газар, аж үйлдвэрийн салбар, олон улсын боловсролын байгууллага гэх мэт хамтын ажиллагааны харилцаа. Олон улсын түншлэл, хамтарсан судалгааны төсөл, цогц сургалт.
- **Нөөц:** Сургуулийн кампусын барилга байгууламж, номын сан, лаборатори, технологийн нөөц.
- **Чанарын баталгаа ба магадлан итгэмжлэл:** Стандарт, үнэлгээний систем, тасралтгүй сайжруулалтын үйл ажиллагаа. Үндэсний хэмжээнд болон олон улсад магадлан итгэмжлэгдсэн лаборатори, аргачлал, сургалтын хөтөлбөр. Олон улсын эрэмбийн системд эзлэх байр.
- **Монгол улсын соёл, түүхийн өв:** Монгол улсын үндэсний үнэт зүйлс, соёлын өв, тэдгээрийг сургалт, судалгаа, байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэж буй байдал

Ийнхүү байгууллагын мэдлэгийг тодорхойлсноор МУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа чанартай явагдаж тасралтгүй шинэчлэл, инновацыг дэмжихэд чухал ач холбогдолтой. МУИС нь байгууллагын мэдлэгийг дараах дотоод болон гадаад эх сурвалж хэлбэртэй хадгалж, боловсронгуй болгож, үйл ажиллагаандаа тасралтгүй хэрэглэж ирлээ. МУИС-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдлэгийн эх сурвалжуудыг дэлгэрэнгүй хэлбэрээр дараах хүснэгтээр жагсаан харууллаа.

Хүснэгт 1. МУИС-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдлэгийн эх сурвалж

Дотоод эх сурвалж	Сургуулийн ерөнхий үйл ажиллагааны хувьд ✓ МУИС-ийн дүрэм, журам ✓ МУИС-ийн баримтжуулсан цаасан, онлайн, цахим мэдээ, мэдээлэл ✓ Бүх шатны нэгжийн хурлын тэмдэглэл, тогтоол, шийдвэр ✓ МУИС-ийн стратеги төлөвлөгөө, эрхэм зорилго, үнэт зүйл, үйл ажиллагааны төлөвлөгөө ✓ МУИС-ийн жил бүрийн тайлан, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах шаардлага, түүний үр нөлөө ✓ Багш, ажилтны хөгжлийн хөтөлбөр ✓ Дотоод, гадаад хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр ✓ Багш, ажилтан солилцоо, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо ✓ Профессор багшийн зэрэглэл, цол олгох тогтолцоо ✓ Судалгааны лаборатори, төвүүд, шинжлэх ухааны парк ✓ МУИС-ийн музей ✓ Амжилттай, амжилтгүй хэрэгжсэн төсөл, хөтөлбөрөөс авсан сургамж, хөгжүүлэлт ✓ Багш ажилтны хуримтлуулсан мэдлэг, чадвараа хуваалцах орчин нөхцөл ✓ Сургалт удирдлагын мэдээллийн систем, эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн систем, төслийн удирдлагын систем, бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем, номын сангийн мэдээллийн систем, цахим номын сан
	Сургалтын үйл ажиллагааны хувьд ✓ Бакалавр, магистр, докторын түвшний сургалтын хөтөлбөр ✓ Бүх шатны сургалтын хөтөлбөрийн иж бүрэн баримт бичиг ✓ Бүх шатны сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлийн хөтөлбөр ✓ Багш нарын лекц, семинар, лабораторийн хичээлийн материал ✓ Хичээлийн явцын болон улирлын үнэлгээний даалгавар ✓ Семинар, лабораторийн гарын авлага, удирдамж ✓ Үйлдвэрлэлийн, хээрийн, багшлах дадлагын удирдамж, гуравласан гэрээ, дэвтэр ✓ Багш нарын зохиосон, орчуулсан ном, сурах бичиг, номын бүлэг ✓ Бакалавр, магистрын судалгааны ажил буюу дипломын ажил, диссертац ✓ Үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэлийн тайлан ✓ Оюутны клубийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан ✓ Оюутанд чиглэсэн оюутан солилцоо, танхимаас гадуурх үйл ажиллагаа, эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль эрх зүй, ажил мэргэжил, карьер хөгжлийн зөвлөгөөний талаарх жил бүрийн тайлан

	✓ Оюутан солилцоо, интерншип хөтөлбөр ✓ Төрөл бүрийн тэтгэлэгт хөтөлбөрүүд
	Судалгааны үйл ажиллагааны хувьд ✓ Үндэсний, хамтарсан, олон улсын судалгааны төсөл, гэрээт ажил, захиалгат ажлын гэрээ, тайлан ✓ Магадлан итгэмжлэгдсэн лаборатори ✓ Эрдэм шинжилгээний өгүүлэл, тойм өгүүлэл ✓ Оюуны өмч: Шинэ бүтээлийн патент, ашигтай загвар ✓ Нэг сэдэвт бүтээл ✓ МУИС-ийн багш, ажилтны мэдлэг, чадвар, хуримтлуулсан туршлага ✓ Багш судлаачийн эшлэлийн тоо ✓ Эрдэм шинжилгээний бүтээлийн чансаа ✓ Байгууллагын дотоодын болон олон улсын эрэмбэ дараалал
Гадаад эх сурвалж	✓ Архив, албан хэрэг хөтлөх стандарт, ✓ Байгууллагын дотоодын эрэмбэ дараалал ✓ Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр ✓ Олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинар, хурлын эмхэтгэл ✓ Дотоодын эрдэм шинжилгээний хурал, семинар, хурлын эмхэтгэл ✓ Эрдэмтдийн уулзалт, яриа, сургалт ✓ Хамтарсан сургалтын болон судалгааны хөтөлбөр ✓ Хамтарсан төсөл, хөтөлбөр ✓ Зочин профессорын хөтөлбөр ✓ Төгсөгчдийн холбооны МУИС-д чиглэсэн үйл ажиллагаа

МУИС нь Хүснэгт 1-д үзүүлсэн дотоод болон гадаад эх сурвалжийг хадгалах, хуваалцах, баяжуулах арга замуудыг дараах байдлаар шийдвэрлэдэг. Үүнд:

МУИС-д сургалт, судалгааны мэдлэгийг хадгалахдаа МУИС-ийн цахим хуудас (<https://www.num.edu.mn/>), сургалт удирдлагын мэдээллийн систем (SIS), эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн систем (RMS), төслийн удирдлагын систем (PMS), бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем (PDS), номын сангийн мэдээллийн систем (Koha), цахим номын сан (Koha), хүний нөөцийн программ (HR), албан хэрэг хөтлөлтийн программ (ABLE) зэрэг системийг ашигладаг.

Түүнээс гадна мэдлэгийн менежментийн Microsoft365: Onedrive, SharePoint, MS Teams, Calendar, Planner зэрэг платформуудыг нийтлэг хэрэглэдэг.

Олон нийтийн форум, цахим уулзалт, семинар зохион байгуулахдаа хамтын ажиллагааны Microsoft365: Onedrive, MS Teams, Calendar, Planner, Zoom, Viber зэрэг систем, Facebook, LinkedIn гэх мэт олон нийтийн сүлжээгээр дамжуулан мэдлэг хуваалцаж байна.

Хурал, семинар, хэлэлцүүлэг хийх, мэдээ, нийтлэл хэвлүүлэх, санал хүсэлт авах, тогтмол шинэчлэх, шалгах, тохируулах, туршлага солилцох замаар байгууллагын мэдлэгийг гүнзгийрүүлэх, баяжуулж байна.

4.6. Чадамж

4.6.1. Ерөнхий зүйл

МУИС нь авьяас чадварыг татах, мэргэшсэн багш нар болон бусад боловсон хүчнийг сонгох, тогтвортой байдлыг хангахад анхаардаг.

Байгууллага боловсролын салбарын олон улсын жишгийн дагуу авьяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр тасралтгүй ажиллаж байна. Процессын гарын авлага - Хүний нөөцийг дараах зорилгоор хэрэгжүүлдэг:

- Гүйцэтгэлд нөлөөлж буй багш, ажилтнуудын шаардлагатай чадамжийг тодорхойлох;
- Эдгээр хүмүүсийг зохих боловсрол, сургалт, туршлагын үндсэн дээр чадвартай эсэхийг баталгаажуулах;
- Ажилтны ажлын үр дүнг үнэлэх арга зүйг тогтоож хэрэгжүүлэх;
- Боломжтой бол шаардлагатай сүүлийн үеийн ур чадварыг эзэмшүүлэх арга хэмжээ авч, авсан арга хэмжээний үр нөлөөг үнэлэх;

- Холбогдох ажилтнуудын ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хангах арга хэмжээ авах;
- Зохио баримтжуулсан мэдээллийг чадварын нотлох баримт болгон хадгалах.

Төрөл бүрийн албан тушаал, ажил үүргийн ур чадварын шаардлагыг тодорхойлохдоо Засгийн газар болон бусад зохицуулалтын агентлагуудын шаардлагыг харгалзан үзсэн.

МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр нь багшийн цогц чадамжид тулгуурлан боловсруулж, сургалт, судалгааны чадвар, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор зохион байгуулдаг. Нийт хамрагдсан багш нарыг тоон хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт . Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан байдал

Чадамж	Сургалтад хамрагдсан багш	Үнэлгээний үзүүлэлт
Судалгааны чадамж: Шинжлэх ухааны салбар, салбар дундын судалгааг олон улсын жишигт нийцүүлэн гүйцэтгэх	8 төрлийн 25 удаагийн сургалт, 795 багш	Судалгааны төслийн тоо, гарсан үр дүн
Сургалтын чадамж: Сургалт, суралцах үйл ажиллагааг орчин үеийн технологи, мэдээллийн хэрэгслээр үр дүнтэй зохион байгуулах	9 төрлийн 18 удаагийн сургалт, 757 багш	Сургалтын чанар, сэтгэл ханамж, ур чадварын үнэлгээ
Хувь хүний чадамж: Ажлын бүтээмж, манлайлал, харилцаа, шинэ мэдлэг эзэмших чадвар	10 төрлийн 21 удаагийн сургалт, 611 багш	Ажилдаа хэрэгжүүлсэн ур чадвар, ахицын үнэлгээ

4.6.2. Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага

МУИС хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын суралцах боломж, орчин нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг, үйлчилгээг үзүүлэх ажлыг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулдаг.

МУИС-ийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй оюутанд хүртээмжтэй орчин бүрдүүлэхэд анхаарч “Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ”-г албан ёсоор хийлгэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулан дараах үйлчилгээг үзүүлдэг:

Санхүүгийн Дэмжлэг: Төрийн буцалтгүй тусламж, Боловсролын зээлийн үйлчилгээнд хамруулах.

Орчны Хүртээмж:

- **Дэд бүтэц:** "Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ"-г албан ёсоор хийлгэсэн.
- **Дотуур байр:** Дотуур байранд давуу эрхтэй сонголт хийлгэх (МУИС-ийн дотуур байрны журам).
- **Тусгай хэрэгсэл:** Дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, хромбүүк, "Ярьдаг, сонсдог" номын сангийн хэсэгтэй.

Сургалтын тохируулга:

- **Давуу эрх:** Хичээл сонгон баталгаажуулах хугацаанаас өмнө Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжийн дэмжлэгтэйгээр хичээл сонгох давуу эрх эдлэх (СҮАЖ 4.5.6).
- **Тохируулга үйлчилгээ:** Хичээл дээр өөрийн хүсэлт, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт үндэслэн шаардлагатай тохируулга хийх (СҮАЖ 4.5.19). Энэ нь суралцагчдад чармайлтаа шударгаар үнэлүүлэх боломжийг нэмэгдүүлдэг.

Сэтгэл зүй, хөгжил: Сэтгэл зүйн засал, сургалт, зөвлөгөөний төвтэй хамтран хөтөлбөр хэрэгжүүлэх.

Чиглүүлэгч хөтөлбөр: “Чиглүүлэгч оюутан” хөтөлбөрийг Оюутны хөгжлийн газар эрхлэн явуулдаг. Уг хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь тэгш хүртээмжтэй үйлчилгээ авах боломжийг бүрдүүлдэг.

Холбогдох баримт бичиг

Сургалтын үйл ажиллагааны журам

“Хичээлийн тохируулга үйлчилгээ” багш оюутанд зориулсан зөвлөмж

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр

МУИС-ийн дотуур байрны журам

4.7. Мэдлэг, ойлголт

Байгууллага нь өөрийн хяналтад ажиллаж буй бүх ажилтан, багш, суралцагч болон холбогдох этгээдэд дараах мэдээллийг ойлгуулж, таниулдаг. Үүнд:

- Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс;
- Боловсролын байгууллагын бодлого, стратеги, холбогдох зорилтууд;
- Менежментийн тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр, тэр дундаа байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр өгөөжийг сайжруулах ач холбогдол;
- Тэдний үйл ажиллагаатай холбоотой бодлого, журам болон бусад баримт бичгүүд;
- Менежментийн тогтолцооны шаардлагыг хангаагүйгээс гарах үр дагавар.

Боловсролын байгууллагын бодлого, стратеги, ББМТ-ны зорилттой уялдах

байдал:

МУИС нь 2016–2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд шинжилгээ хийсний үндсэн дээр 2025–2030 онд баримтлах стратеги төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд уг баримт бичгийг багш, ажилтан, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөллийн өргөн оролцоотойгоор шинэчлэн баталсан. Шинэ стратегийн талаар:

- Төв байрны үүдний танхимд болон цахим сувгуудаар танилцуулж, нийт багш, ажилтан, суралцагчдад хүргэж байна.
- Ажилтан бүр өөрийн цахим системээр нэвтрэхийн өмнө байгууллагын 2030 он хүртэлх хөгжлийн зорилго, стратегийн талаарх мэдээллийг өдөр бүр харах боломжтой.
- Жил бүр зохион байгуулагддаг шинэ багшийн чиглүүлэх хөтөлбөрийн хүрээнд бодлого, стратеги, дүрэм журмыг танилцуулж, ажлын ур чадвар, үүрэг хариуцлагын талаар сургалт явуулдаг.

МУИС нь дотоод болон гадаад харилцаанд мөрдөх 66 дүрэм журамтай бөгөөд эдгээрийг цахим хуудсандаа (<https://www.num.edu.mn/regulations/>) байршуулан багш, ажилтан, суралцагчдын хэрэгцээнд нээлттэй мэдээллийн сан болгон ашиглуулж байна.

Боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ ба хувь нэмэр:

Шинэ стратегийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн ажлын төлөвлөгөө, хөтөлбөрт тусган хэрэгжүүлдэг. Мөн Ректорын 2024 оны А/260 дугаар тушаалаар “МУИС-ийн удирдах болон гүйцэтгэх ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам” батлагдсан. Энэ журам нь төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үнэлгээ болон сайжруулалтын үйл явцыг зохицуулдаг.

ББМТ-ны шаардлагыг хангаагүйгээс гарах үр дагавар:

Багш, ажилтны мэдлэг, ур чадварын түвшин, мэргэжлийн өсөлтийг үнэлэх зорилгоор “Багшийн ажлын нэгдсэн үнэлгээ (аттестатчилал)-ний журам” болон “Гүйцэтгэх ажилтны нэгдсэн үнэлгээний журам”-ыг хэрэгжүүлдэг. Эдгээрийн хүрээнд шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн ажилтны ажлын үнэлгээ, цаашдын ажиллах боломж, мэргэжлийн хөгжилд нөлөөлөх үр дагавар үүснэ.

4.8. Харилцаа холбоо

4.8.1. Ерөнхий зүйл

МУИС нь менежментийн тогтолцоонд хамаарах дотоод болон гадаад харилцааны шаардлагыг тодорхойлох зорилгоор “Харилцааны матриц”-ыг боловсруулан ашигладаг. Харилцааны матрицад дараах зүйлс орно.

- Юу харилцах;
- Яагаад харилцах;
- Хэзээ харилцах;
- Хэнтэй харилцах;
- Хэрхэн харилцах;
- Хэн харилцах;

4.8.2. Харилцаа холбооны зорилго

МУИС нь дотоод болон гадаад харилцаа холбоог дараах зорилгоор хэрэгжүүлдэг. Үүнд:

- Холбогдох сонирхогч талуудын санал, зөвшөөрөл авах;
- Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, стратеги, бодлоготой нийцсэн, холбогдох, үнэн зөв, шуурхай мэдээллийг сонирхсон этгээдэд хүргэх;
- Байгууллагын хүрээнд холбогдох сонирхогч талуудтай хамтран ажиллаж, үйл ажиллагаа, үйл явцыг зохицуулах.

4.8.3. Харилцаа холбооны зохицуулалт

МУИС нь дараах асуудлаар суралцагчид болон бусад сонирхогч талуудтай харилцах үр дүнтэй зохицуулалтыг тодорхойлж хэрэгжүүлдэг.

- Байгууллагын бодлого, стратеги төлөвлөгөө;
- Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний загвар, агуулга, хүргэлт;
- Лавлагаа, өргөдөл, элсэлт, бүртгэл;
- Суралцагчдын гүйцэтгэлийн мэдээлэл, үүнд хэлбэржүүлэх болон нэгтгэсэн үнэлгээний үр дүн;
- Суралцагчийн гомдол, суралцагчид/сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа зэрэг суралцагч болон сонирхогч талуудын санал хүсэлт.

МУИС нь шийдэгдээгүй асуудал гарсан тохиолдолд гадаад холбоо барих талаар суралцагчид болон бусад үр шим хүртэгчдэд мэдээлдэг. Байгууллага нь харилцааныхаа хэрэгжилтэд хяналт тавьдаг; хяналтын үр дүнд үндэслэн харилцаа холбооны матрицад дүн шинжилгээ хийж сайжруулдаг.

Байгууллага нь харилцааны үйл явцыг баримтжуулсан мэдээллээр хадгалж, цахим харилцааг зохицуулах журмаар цахим болон олон нийтийн харилцааг удирддаг.

Холбогдох баримт бичиг:

Харилцааны матриц -NUM/EOMS/FMT/013

4.9. Баримтжуулсан мэдээлэл

МУИС-ийн баримт бичгийн бүтцийг түүний хэмжээ, үйл ажиллагааны төрөл, үйл явцын нарийн төвөгтэй байдал, тэдгээрийн харилцан үйлчлэл, боловсон хүчний чадамж, байгууллагын дагаж мөрдөх үүргийг харгалзан тодорхойлдог. Бүтэц нь дараах байдалтай байна.



“Баримтжуулсан мэдээлэлд хяналт тавих журам” (NUM/EOMS/PRO/002)-ыг баримтжуулсан мэдээллийг бий болгох, шинэчлэх, хянах зорилгоор хэрэгжүүлдэг.

Холбогдох баримт бичиг:

Баримтжуулсан мэдээллийг хянах журам (NUM/EOMS/PRO/002) -Хавсралт-XXIX

МУИС-ийн Албан хэрэг хөтлөлтийн журам

Үйл ажиллагаанд ашигладаг гарын авлагууд

Тодорхой хөтөлбөрүүдийн удирдамж

Маягтууд

Бүртгэл (системээр болон бусад)

БҮЛЭГ 5: АЖИЛЛАГАА (21001:2018 стандарт, бүлэг 8)

5.1. Ажиллагааны төлөвлөлт ба хяналт

Монгол Улсын Их Сургууль (МУИС) нь улс орны хөгжлийн тулгуур, мэдлэгийн цөм болсон үндэсний тэргүүлэх судалгааны их сургууль байж, нийгэм, эдийн засгийн эрэлт шаардлагад нийцсэн олон улсын түвшний судалгаа, сургалт явуулж, шинжлэх ухааны мэдлэг эзэмшсэн, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх үүрэгтэй. Сургалт, эрдэм шинжилгээ, оюутанд үзүүлэх үйлчилгээг хичээлийн жил бүрээр “Нэгдсэн хуанли”-г нарийвчлан төлөвлөж, захирлын зөвлөлийн хурлаар батлуулан мөрдөж ажиллана. Хуанли цахим нээлттэй тавьж, мэдээлнэ.

5.1.1. Ерөнхий зүйл:

МУИС нь боловсролын үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлагыг хангах, 3.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл явцыг дараах байдлаар төлөвлөж, хэрэгжүүлж, хянадаг.

- Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлох;
- Үйл явцын шалгуурыг тогтоох;
- Боловсролын үйлчилгээний шаардлагад нийцүүлэхэд шаардагдах нөөцийг тодорхойлох;
- Шалгуур үзүүлэлтийн дагуу үйл явцын хяналтыг хэрэгжүүлэх;
- Шаардлагатай хэмжээнд баримтжуулсан мэдээллийг тодорхойлох, хадгалах;
- Үйл явц төлөвлөсний дагуу хэрэгжиж буй эсэхийг баталгаажуулах;
- Боловсролын үйлчилгээ нь тэдний шаардлагад нийцэж байгааг нотлох.

МУИС нь аливаа сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах замаар төлөвлөсөн өөрчлөлтийг хянаж, хүсээгүй өөрчлөлтийн үр дагаврыг хянана. МУИС нь гаднаас үйлчилгээ үзүүлэгчийн бүх үйл явцыг худалдан авах үйл явцын гарын авлагын дагуу хянаж байхыг баталгаажуулдаг.

5.1.2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний тусгай ажиллагааны төлөвлөлт, хяналт

МУИС нь хөтөлбөрийн гарын авлагаар дамжуулан боловсролын үйлчилгээний загвар, боловсруулалт болон хүлээгдэж буй үр дүнг төлөвлөдөг бөгөөд үүнд:

- Сургалтын үр дүн;
- Тохиромжтой, хүртээмжтэй заах арга зүй, сургалтын орчныг хангах;
- Сургалтын үнэлгээний шалгуурыг тодорхойлох;
- Сургалтын үнэлгээ хийх;
- Сайжруулах аргуудыг тодорхойлох, хэрэгжүүлэх;
- Суралцагчид чиглэсэн үйлчилгээ үзүүлэх ажиллагаа багтана.

5.1.3. Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага

МУИС нь дараах зорилгоор тусгай хэрэгцээт боловсролын Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан үйлчилгээг үзүүлэх бодлогыг баримтжуулж, хэрэгжүүлдэг. Суралцагчийг ур чадвар, чадвар, сонирхолд тулгуурлан суралцах үйл явцыг хамтран бүтээхэд нь дэмжлэг үзүүлэн, уян хатан ханддаг, үүнд:

- Дасан зохицох зааварчилгаа;
- Түргэвчилсэн буюу баяжуулсан контент;
- Хоёр өөр хөтөлбөрт эсвэл боловсролын байгууллагад элсэхийг зөвшөөрөх;
- Тус тусад нь тохирсон арга хэмжээ;
- Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх, хөтөлбөрийг суралцагчийн онцлогт тохируулан өөрчлөх, тухайн хичээл, хичээлийн насны онцлогт тохирсон үнэлгээ эсвэл түвшний хүлээлтээс дээгүүр эсвэл доогуур байх;
- Өмнө нь сурч байсан туршлагыг хүлээн зөвшөөрөх;
- Суралцагчдыг оновчтой боломжоор хангахад нь дэмжлэг үзүүлэх хангалттай нөөц бололцоо бүхий багийн орчныг бүрдүүлэх;
- Ажлын байрны боломжуудтай уялдаа холбоотой байх;
- Шаардлагатай бол эрүүл, тэжээллэг хоолоор хангах.

Лавлах баримт бичиг:

Өөрчлөлтийн менежментийн журам (NUM/EOMS/PRO/006) Хавсралт-VII

Процессын гарын авлага - Худалдан авалт- (NUM/EOMS/PFC/012) Хавсралт-XIX

Хөтөлбөрийн гарын авлага

Сургалтын нэгдсэн хуанли

5.2 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлага

5.2.1 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагыг тодорхойлох

Суралцагч болон бусад үр шим хүртэгчдэд санал болгох боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлохдоо МУИС дараах зүйлийг харгалзан үзнэ.

- Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлага
- МУИС-ийн стратегийн төлөвлөгөөнд тусгасан шаардлага
- Суралцагчид, үйлчлүүлэгч, ялангуяа тусгай хэрэгцээт суралцагчдын шаардлагыг тодорхойлохоор гүйцэтгэсэн хэрэгцээний судалгааны үр дүнгээс бий болсон шаардлага
- Олон улсын шаардлага, хөгжлөөс урган гарсан шаардлага;
- Хөдөлмөрийн зах зээлийн шаардлага
- Судалгааны үр дүнд бий болсон шаардлага
- Зохих эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага
- Тусгай боловсролд тавигдах шаардлага

Олон улсын эрэлт, хэрэгцээ, чиг хандлага

МУИС нь санал болгож буй боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдсан шаардлагыг хангана.

Дээрх шаардлагыг хангасан мэргэжилтэн бэлтгэн гаргахын тулд сургалтын хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт болон хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилтуудын

уялдаа холбоо мөн хичээл бүрээр эзэмших мэдлэг, ур чадварын уялдаа холбоог гаргана. Харин шаардлага өөрчлөгдсөн бол элсэлтийн журам болон сургалтын хөтөлбөрийг өөрчилж, мэдээлнэ.

5.2.2 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлагыг мэдээлэх

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийн өмнө суралцагчдад болон бусад холбогдох сонирхогч талуудад мэдэгдэхийн тулд оюутны гарын авлага, оюутны портал дээрх мэдээллээр хангадаг бөгөөд зохих тохиолдолд тэдний ойлголтыг шалгадаг:

- Сургуулийн танилцуулга
- Суралцах гэрээ
- Оюутны гарын авлага (Сургалтын төлөвлөгөө, Сургалтын үнэлгээ)
- Судлах хичээл тус бүрийн мэдээлэл
- Сургуулийн зүгээс үзүүлэх тэтгэлэг, хөтөлбөр, грант
- Сургалтын төлбөр
- Оюутны дотуур байрны төлбөрийн мэдээлэл

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журам
- Сургалтын үйл ажиллагааны журам
- Бакалаврын өдрийн хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилийн намрын улиралд оюутан элсүүлэх журам
- Бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам
- Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам
- Суралцагч шилжүүлэн суралцуулах журам
- Хичээл дүйцүүлэх журам
- МУИС-ийн суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам

5.2.3 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагын өөрчлөлт

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагуудыг өөрчлөх үед холбогдох баримтжуулсан мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулж, холбогдох сонирхогч талууд өөрчлөлтийн талаар мэдээллээр хангана.

5.3 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн, боловсруулалт

5.3.1 Ерөнхий зүйл

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний дараах үйлчилгээг хангахад тохирсон дизайн ба боловсруулалт хийх үйл явцыг бий болгож, хэрэгжүүлж, мөрдөнө.

Боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлага/стандартыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр хөтөлбөрийг дотооддоо хянаж, батална.

5.3.2 Дизайн ба боловсруулалтын төлөвлөлт

МУИС нь суралцагч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг дээд газраас тавьдаг нийтлэг шаардлагын дагуу сургалтын хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулж, тасралтгүй сайжруулна.

Шинэ шаардлага (Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага) А/147 тушаал болон "Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журам"-д нийцүүлэн хөтөлбөрийн хөгжүүлэлт, сургалтын чанар, суралцагчийн амжилтыг дээшлүүлэх үүднээс бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд үндсэн болон дагалдах баримтын дагуу шинэчлэн боловсруулсан.

Дизайн ба боловсруулалт хийх үе шатыг тодорхойлж, хянахын тулд байгууллага дараах зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

- ISO 21001:2018 стандартын 8.2-т заасан шаардлага

- Дизайн ба боловсруулалтын мөн чанар, үргэлжлэх хугацаа, төвөгшил
- хэрэглэгдэх дизайн ба боловсруулалтын дүн шинжилгээг хамруулаад шаардлагатай үйл явцын үе шат
- шаардлагатай дизайн ба боловсруулалтыг шалган батлах, баталгаажуулах арга хэмжээ
- дизайн ба боловсруулалтын үйл явцын хамаарах хариуцлага, эрх мэдэл
- бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн ба боловсруулалтад шаардлагатай гаднын болон дотоод нөөц
- дизайн ба боловсруулалтын үйл явцад оролцож байгаа ажилтнуудын харилцааг хянах хэрэгцээ
- дизайн ба боловсруулалтын үйл явцад суралцагчид, үйлчлүүлэгчдийн оролцох хэрэгцээ
- боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний дагалдах үйлчилгээнд тавих шаардлага
- дизайн ба боловсруулалтын үйл явцад суралцагч, үйлчлүүлэгч, сонирхогч талуудын хийх хяналтын хүлээгдэж буй түвшин
- дизайн ба боловсруулалтад тавих шаардлага хангасныг батлах баримтжуулсан мэдээлэл
- нотолгоонд суурилсан хандлага
- суралцагчийн чадвар, сонирхол, туршлагадаа үндэслэн тэдгээрийн хүсэж буй тусгай сургалтын чиглэл
- хичээл шинээр зохиох, хөгжүүлэх, сургалтад хэрэглэх арга хэрэглэлийг дахин ашиглалт, хүртээмж, шилжих байдал, ашиглалтын хугацааны шаардлага

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журам
- Сургалтын үйл ажиллагааны журам
- Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага A/147
- Бакалаврын төгсөгчдөд тавих нийтлэг шаардлага
- Сургалтын хөтөлбөрийн үндсэн баримт бичиг
- Сургалтын хөтөлбөрийн дагалдах баримт бичиг

5.3.3 Дизайн ба боловсруулалтын орц

МУИС хөтөлбөр болон сургалтын хөтөлбөр боловсруулахдаа дараах орцуудыг харгалзан үзнэ.

- Үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлага
- Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт
- Өмнө нь хийж байсан ижил төстэй хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл
- Холбогдох дүрэм, журам, стандартууд
- Хөтөлбөрийн эрсдэл ба үр дагавар
- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлох
- Амжилттай заах, сурахад дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай нөөц зэргийг тодорхойлно.



МУИС оролтыг бүрэн гүйцэд, хоёрдмол утгагүй, дизайн, хөгжүүлэлтийн зорилгод тохирсон эсэхийг баталгаажуулдаг. Зөрчилтэй дизайн, боловсруулалтын орцыг хэрэв байгаа бол шийдвэрлэнэ.

МУИС нь хөтөлбөрийн дизайн болон сургалтын хөтөлбөр боловсруулах орцын талаарх баримтжуулсан мэдээллийг хадгалдаг.

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд батлагдсан баримт бичгийн дагуу нийтлэг загвар, маягтын дагуу дараах баримт бичгүүдийг боловсруулна. Үүнд:

- Сургалтын төлөвлөгөө
- Хичээлийн хөтөлбөр
- Хичээлийн залгамж холбоо
- Оюутанд хүргэх жишиг төлөвлөгөө

5.3.4 Дизайн ба боловсруулалтын хяналт

5.3.4.1 Ерөнхий зүйл

МУИС дараах зүйлийг баталгаажуулахын тулд хөтөлбөрийн дизайн болон сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцад хяналт тавьсан:

- Хүрэх үр дүнг тодорхойлсон;
- Зураг төсөл боловсруулах ажлын үр дүнгийн шаардлагад тохирч байгаа эсэхийг үнэлэх зорилгоор үнэлгээ хийдэг;
- Үүссэн боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь заасан хэрэглээ, зориулалтын шаардлагад тохирч байгаа эсэхийг баталгаажуулах үйл ажиллагаа явуулдаг;
- Шинжилгээ, баталгаажуулалтын явцад илэрсэн асуудлын талаар шаардлагатай арга хэмжээг авдаг.

Байгууллага дараах шаардлагатай баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. Үүнд:

- Аливаа шинжлэх, магадлан шалгах, баталгаажуулах үйл ажиллагааны үр дүн;
- Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах аливаа шинэ шаардлага.

5.3.4.2 Боловсролын үйлчилгээний дизайн ба боловсруулалтын хяналт

Дизайн ба боловсруулалтын үйл явцад хийх хяналт дараах байдлыг хангана. Үүнд:

- Хүрэх гэж буй үр дүнг тогтоох
- Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын үр дүн шаардлага хангах чадвартайг үнэлэх зорилгоор хянах
- Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын гарц нь орцын шаардлага хангасныг нотлох зорилгоор шалгалтын үйл ажиллагаа явуулсныг

- Эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зориулалтын болон тодорхой хэрэглээний шаардлагыг хангаж байгааг тодорхойлохын тулд баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулсныг
- Дүн шинжилгээ хийх, хянах, шалгах, баталгаажуулах явцад гарсан шаардлагатай аливаа асуудлыг шийдвэрлэх
- Эдгээр арга хэмжээний талаарх мэдээллийг хөтөлж баримтжуулан хадгалах нөхцөлийг хангана.

5.3.4.3 Сургалтын хөтөлбөрийн дизайн ба боловсруулалтын хяналт

Сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцад тавих хяналт нь дараах зүйлийг хангана.

Сургалтын гарц нь:

- Хичээл, хөтөлбөрийн хамрах хүрээнд тохирсон байна.;
- Хөтөлбөрийг дүүргэснээр олж авах суралцагчдын чадамжийн тогтоосон түвшин байна
- Чадамж нь ямар түвшинд хүрэх үзүүлэлтийг багтаасан байна;
- Тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, уялдаатай, хугацаатай байна.

Суралцах үйл ажиллагаа нь:

- боловсрол олгох арга аргачлалд тохирсон байна.
- сургалтын гарцыг хангахыг батлахад тохиромжтой байна.
- тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, уялдаатай, хугацаатай байна.

Суралцахуйн үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэхэд шаардлагатай бүх нөөцийг тодорхойлно. Сургалтын дизайнд тохиромжтой боломжуудыг багтаана. Үүнд:

- Суралцагчид сургалтын үйл явцыг бий болгоход идэвхтэй үүрэг оролцоо
- Төлөвшлийн үнэлгээ, эргэх холбоо

5.3.4.4 Дүнгийн үнэлгээний дизайн ба боловсруулалтын хяналт

Дүнгийн үнэлгээний дизайн ба боловсруулалтын үйл явцад хийх хяналт нь дараах зүйлийг батална. Үүнд:

- үнэлгээний дизайн болон үнэлгээ хийх, суралцахуйн үйл ажиллагаанаас гарах сургалтын гарц хоорондын тодорхой холбоог харуулна.
- суралцагчдын хувьд ил тод, хүртээмжтэй, ялангуяа дүнгийн онооны хувьд шударга байх зарчмаар үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- дүнгийн онооны системийг тогтоож, баталгаажуулсан байна.

5.3.5 Дизайн ба боловсруулалтын гаралт

Байгууллага нь дизайн ба боловсруулалтын гаралт нь:

- Оролтын шаардлагыг хангах
- Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх үйл явцын дагалдах үйлчилгээнд тохирсон байх
- Мониторинг ба хэмжилтийн тохирох шаардлага болон хүлээн авах шалгуурыг тусгах буюу иш татах
- Зориулалтад нийцэх боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг зөв, аюулгүй байдлаар үзүүлэхэд чухал шинж чанарыг тодорхой заах
- Баримтжуулсан мэдээллийг хадгалж байхыг батална.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан анхан, дунд, дээд шатны хөтөлбөрийн хороодоор хэлэлцсэн хурлын шийдвэр:
 - Тэнхимийн хөтөлбөрийн хороо (анхан шатны хороо)
 - Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо (дунд шатны хороо)
 - Хөтөлбөрийн ерөнхий хороо (дээд шатны хороо)

5.3.6 Дизайн ба боловсруулалтын өөрчлөлт

Байгууллага боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагын тохирол эсвэл үр дүнд сөрөг нөлөөгүй байдлыг хангах хэр хэмжээнд дизайн ба боловсруулалтын явцад эсвэл дараа нь гарах өөрчлөлтийг тогтоож, дүн шинжилгээ хийж, хянаана.

Байгууллага дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. Үүнд:

- a. Дизайн ба боловсруулалтын өөрчлөлт
- b. Дүн шинжилгээний гаралт
- c. Өөрчлөлтийн зөвшөөрөл
- d. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээ

Лавлагаа баримт бичиг:

Хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан анхан, дунд, дээд шатны хөтөлбөрийн хороодоор хэлэлцсэн хурлын шийдвэр

Төгсөх түвшний судалгааны үр дүн

Төгсөгчдийн судалгааны үр дүн

Сэтгэл ханамжийн судалгаа


5.4 Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт

МУИС гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийж, хяналт тавина. Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээг дараах тохиолдолд тодорхойлно. Үүнд:

- гаднаас нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй нэгтгэх бол
- суралцагчид, үйлчлүүлэгчид шууд хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээг гаднын нийлүүлэгч байгууллагын нэрийн өмнөөс хүргэх бол
- үйл явц болон түүний хэсгийг байгууллагын шийдвэрийн дагуу гаднын нийлүүлэгч гүйцэтгэж байгаа бол.

Гаднын нийлүүлэгчдийн шаардлагын дагуу үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээг хангах чадварт үндэслэн гүйцэтгэлийг үнэлэх, сонгох, мониторинг хийх, дахин үнэлэх шалгуурыг байгууллага тодорхойлж, хэрэглэнэ. Сургууль эдгээр үйл ажиллагаа болон үнэлгээний дүнгийн дагуу хийсэн шаардлагатай арга хэмжээний талаарх баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална. МУИС нь худалдан авах баримтжуулсан үйл явцын гарын авлагын дагуу үйл явц эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх чадварт үндэслэн гаднын нийлүүлэгчдийг үнэлэх, сонгох, гүйцэтгэлд хяналт тавих, дахин үнэлгээ хийх шалгууруудыг тодорхойлж, хэрэгжүүлсэн. Байгууллага нь ханган нийлүүлэгчийг сонгох, батлах, гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ зэрэг худалдан авалтын үйл ажиллагааны баримтжуулсан мэдээллийг хадгалдаг.

МУИС доорх үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээг гаднаас авна:



5.4.1 Хяналтын төрөл ба хэр хэмжээ

МУИС гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь өөрийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг суралцагч, үйлчлүүлэгчдэд тогтвортой хүргэх чадварт сөргөөр нөлөөлөхгүй байх нөхцөлийг хангана. МУИС нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гаднаас нийлүүлж буй үйл явцыг сургуулийн чанарын менежментийн тогтолцооны хяналтад байлгах;
- Нийлүүлэгч болон түүний гаргаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд чиглэсэн хяналт тогтоох;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь шаардлага хангах байгууллагын чадварт бодитой нөлөөлөх эсэхэд анхаарах;
- Гаднын нийлүүлэгчдийн хэрэгжүүлж буй хяналтын үр нөлөөг үнэлэх;
- Шаардлагатай тохиолдолд нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд шалгалт, баталгаажуулалт болон бусад арга хэмжээг тодорхойлох.

5.4.2 Гаднын нийлүүлэгчдэд зориулсан мэдээлэл

МУИС нь гаднын нийлүүлэгчтэй холбоо тогтоохоос өмнө тавих шаардлагын тохиромжтой байдлыг хангана. Сургууль нь дараах шаардлагыг гаднын нийлүүлэгчдэд мэдээлнэ. Үүнд:

- Нийлүүлэх үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар,
- Арга хэрэгсэл, үйл явц, тоног төхөөрөмжийн баталгаат байдал,
- Ажилтнуудын мэргэшсэн байдал зэрэг чадамж,
- Гүйцэтгэлд байгууллагаас хийх хяналт, мониторинг,
- Гаднын нийлүүлэгчийн байранд байгууллага эсвэл суралцагчид үйлчлүүлэгчдийн хийх шалгалт буюу баталгаажуулалт.

Лавлах баримт бичиг:

Процессын гарын авлага - Худалдан авалт үйл явцын урсгал диаграмм (NUM/EOMS/PFC/012) Хавсралт-ХІХ

МУИС-ийн хөдөлмөрийн дотоод журам

МУИС-д зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам

МУИС-ийн үйлчилгээний нэгдсэн стандарт

МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах түр журам

Хамтын ажиллагааны гэрээ байгуулах тухай журам
 Суралцагч бусад их сургуулиас хичээл судлах үйл ажиллагааг зохицуулах журам
 Цахим харилцааг зохицуулах журам
 МУИС-ийн эзэмшлийн авто тээврийн хэрэгслийг ашиглаж журам

5.5 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх

5.5.1 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхэд тавих хяналт

5.5.1.1 Ерөнхий зүйл

МУИС нь санал болгож буй боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг хангах нөхцөлийг бүрдүүлж, хяналтын шалгуурыг тогтоон хэрэгжүүлнэ.

Дараах зүйлийг тодорхойлох баримтжуулсан мэдээлэл бий болгож, хадгална. Үүнд:

- Элсэлтийн журам
- Бүртгэлийн нэгдсэн систем (<https://burtgel.num.edu.mn/>) -ээр элсэх хүсэлтээ гаргах
- Элссэн хөтөлбөрөө баталгаажуулах
- Оюутны дугаар авах
- Элсэлтийн тушаал гаргах
- Суралцагчдад зориулсан чиглүүлэх сургалт
- Суралцах хувийн төлөвлөгөө зохиох
- Судлах хичээлээ сонгож баталгаажуулах

Үйл явц бүрийг шалгуурын дагуу хянана. Холбогдох салбар нэгжүүд баримтжуулсан мэдээллийг шаардлагын хэмжээнд тодорхойлж, бүртгэж хадгална. Үүнд:

- Үйл явц төлөвлөсний дагуу зохион байгуулагдсанд итгэлтэй байхын тулд бүх үйл ажиллагааг бүрэн баримтжуулж, хадгална.
 - Мөн шаардлагатай үед мөшгөн тогтоох боломж бүрдүүлнэ.
 - Бүтээгдэхүүн, үйлчилгээ тавигдаж байгаа шаардлагад нийцэж байгааг харуулах, нотлохын тулд баримтжуулсан байна.
 - Жишээ: Сургалтын тайлан, хурлын тэмдэглэл, багшийн дэвтэр гэх мэт
- Мониторинг, хэмжилтийн зохих, баталгаажсан нөөцийн бэлэн байдал болон хэрэглээ:*

МУИС нь суралцагч болон бусад үр шим хүртэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг эрх бүхий дээд байгууллагаас гаргасан шаардлагын дагуу МУИС-ийн нийтлэг дүрэм журмаар сургалтын хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулж, тасралтгүй сайжруулах арга хэмжээг авна. Сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-өөс тогтоосон шалгуур шаардлага, холбогдох дүрэм журамд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан МУИС-ийн Хөтөлбөрийн Ерөнхий хороогоор хэлэлцэгдэн ректорын тушаалаар баталгаажуулна.

Сургалтын хөтөлбөрийн үр дүнг мэргэжлийн салбарын профессор, багш нар, суралцагчид, төгсөгчид, ажил олгогчдын санал, хөдөлмөрийн зах зээлийн шаардлагаар дотоод болон хөндлөнгийн хяналтаар үнэлүүлэн мониторинг хийж, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийг хийнэ. Сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын шинэ хөтөлбөр, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын бүтээгдэхүүнийг бий болгох, одоо ашиглаж байгаа сургалтын арга, технологио сайжруулах, хөгжүүлэх ажлыг өөрсдийн нөөцөд тулгуурлан, гаднын байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллана.

- Үйл явц эсвэл гаралтыг хянах шалгуурыг баталгаажуулах болон боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний босго шалгуурыг хангаж байгааг баталгаажуулахын тулд холбогдох үе шатууд дахь санал гомдол, бусад эргэх холбоо, төлөвшлийн үнэлгээний үр дүнг хамруулсан мониторинг, хэмжилтийн үйл ажиллагааны хэрэгжүүлэх

МУИС-ийн төгсөлтийг Сургалтын үйл ажиллагааны журмын дагуу намар, хаврын улиралд явагдана. Уг журмаар төгсөгч нь суралцаж буй хөтөлбөрөө бүрэн дүүргэсэн, сургалтын төлөвлөгөөнд тусгасан багц цагийг бүрэн цуглуулж, хөтөлбөрийн болон төгсөгчдөд тавих

нийтлэг шаардлага хангасан байна. Дээрх шаардлагуудын биелэлтийг үндэслэн МУИС-ийн ректорын тушаалаар бакалавр, магистр, докторын зэргийн диплом олгоно.

• *Үйл ажиллагаанд тохиромжтой дэд бүтэц ба орчныг ашиглах*

МУИС нь сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулах, суралцагч бие даан суралцах, мэдлэгээ хэрэгжүүлэх, хооллох, амрах, амьдрах нөхцөлийг боломжит хэмжээнд бүрдүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тохиромжтой дэд бүтцээр хангана. Дэд бүтцэд дараахыг авч үзэх ба эдгээр нь сургалт явуулах, суралцагч бие даан суралцах, сурсан мэдлэгээ хэрэгжүүлэх, хооллож амрах, амьдрахад тохирсон байна.

Лавлах баримт бичиг:

Процессын гарын авлага - Сургалтын тэнхимийн үйл явц (NUM/EOMS/PFC/001)-Хавсралт-IX

Процессын гарын авлага – Сургалт (NUM/EOMS/PFC/018) Хавсралт-XXV

Процессын гарын авлага - Багшлахуй ба суралцахуй үйл явц (NUM/EOMS/PFC/002) Хавсралт-X

Процессын гарын авлага – Шалгалт (NUM/EOMS/PFC/008) Хавсралт-XVI

Процессын гарын авлага - Оюутны хөгжлийн үйл явц (NUM/EOMS/PFC/006) Хавсралт-XIV

Процессын гарын авлага - Стратегийн хөтөлбөр (NUM/EOMS/PFC/015) Хавсралт-XXII

Процессын гарын авлага - Оюутны суралцахуй – (NUM/EOMS/PFC/016) Хавсралт-XXIII

МУИС-ийн дүрэм

Хөдөлмөрийн дотоод журам

Багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм

Үйлчилгээний нэгдсэн стандарт

Судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааны журам,

Байгалийн ухааны лабораторийн хичээл явуулах үйл ажиллагааны ерөнхий журам

ТҮЦ машиныг ашиглах журам,

Оюутны дотуур байрны журам,

Номын сангийн журам,

Судалгааны лаборатори ажиллуулах журам,

Пост-доктор ажиллуулах журам,

Суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам,

• *Шаардлагатай мэргэшлийн түвшин бүхий чадамжтай ажилтныг томилох*

МУИС нь ур чадвартай багш, мэргэжилтэн сонгон шалгаруулж, тогтвортой ажиллуулахад анхаарна. Орчин үед хурдацтай өөрчлөгдөж байгаа боловсролын салбарын зорилго, шинэ шаардлагатай уялдуулан хүний нөөцийн чадамжийг тасралтгүй хөгжүүлэх зорилтыг тавьж ажиллана. Үүнд:

- Хөдөлмөрийн дотоод журам,
- “МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- МУИС-ийн Хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээний журам,
- МУИС-ийн гүйцэтгэх ажилтны нэгдсэн үнэлгээ (аттестатчилал)-ын журам батлах тухай

Хүний алдаанаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх:

Сургалтын хөтөлбөр, элсэлт, сургалт, төгсөлтийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам зөрчигдөх, үйл ажиллагааны явцад алдаа гарах, сонирхогч талуудаас ирсэн гомдол зэрэг нь сургуулийн үйл ажиллагаанд хамаарах үл тохирол болох бөгөөд түүнийг илрүүлэх, хянах, залруулах, сэргийлж холбогдох дүрэм журмыг МУИС-ийн веб хуудсанд нээлттэй байршуулдаг. Үл тохирол бүхий гаралтуудыг шийдвэрлэх Үл тохирол бүхий гаралтуудыг шийдвэрлэхдээ дараах арга хэмжээнүүдээс нэг ба хэд хэдийг тохиромжтой байдлаар хэрэглэнэ. Үүнд:

а) Залруулах арга хэмжээ авах;

б) Үл тохирол бүхий бүтээгдэхүүн үйлчилгээг тусгаарлах, буцаах, битүүмжлэх;

с) Суралцагчид болон бусад үр шим хүртэгчдэд мэдээлэх;

д) Тохиролцооны үндсэн дээр хүлээн зөвшөөрүүлэх.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Сургалтын үйл ажиллагааны журам
- Бакалаврын өдрийн хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилийн намрын улиралд оюутан элсүүлэх журам
- Бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам
- Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам
- Суралцагч шилжүүлэн суралцуулах журам
- Хичээл дүйцүүлэх журам
- МУИС-ийн суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам

5.5.1.2 Элсэлт

5.5.1.2.1 Элсэлтийн өмнөх мэдээлэл

МУИС нь суралцагчдыг элсүүлэхийн өмнө дараах мэдээллээр хангана. Үүнд:

- Шинээр элсэн суралцаж байгаа болон бусад сургалтын шаардлагын суралцагчдад үйлчилгээний дагуу мэргэжлийн суралцах зориулалт, тодорхойлолт, эзэмших мэдлэг, чадвар, дадал, судлах хичээлийн жагсаалт, тэдгээрийн багц цаг, өмнөх хичээлийн холбоо зэргийг тусгасан баримт бичгийг ил тод байршуулна.

МУИС-ийн сургалтын үйл ажиллагаа дараах мөчлөгөөр тасралгүй явагдана. Үүнд:

- БЯ-ны сайдын “Босго оноо тогтоох тухай” тушаал
- Элсэлтийн журам
- Бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам
- Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам
- МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журам
- Элсэлтийн тушаал

5.5.1.2.2 Элсэлтийн нөхцөл

МУИС нь суралцагчдыг элсүүлэх үйл явцыг бий болгож, "элсэлтийн үйл явцын гарын авлага" болгон баримтжуулсан. Баримтжуулсан элсэлтийн бодлогыг жил бүр дараах зорилгоор бэлтгэж, нийтэд мэдээлдэг. Дараах зүйлд нийцсэн элсэлтийн шалгуурыг бий болгох:

- Байгууллагын шаардлага;
- Мэргэжлийн чиглэлээр тавигдах шаардлага;
- Хөтөлбөрийн агуулга ба/эсвэл сурган хүмүүжүүлэх арга барилаас шалтгаалсан шаардлага;

Байгууллага нь элсэлтийн шалгуур, үйл явцыг бүх суралцагчдад нэгэн жигд хэрэглэж, элсэлтийн шийдвэр бүрийг хянах боломжийг баталгаажуулдаг. Элсэлтийн өргөдөл, элсэлтийн зөвшөөрлийн шийдвэрийг баримтжуулсан мэдээлэл болгон хадгална.

Лавлах баримт бичиг:

Процессын гарын авлага – Элсэлт (NUM/EOMS/PFC/003) Хавсралт-XI

Бакалаврын өдрийн хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилийн намрын улиралд оюутан элсүүлэх журам

Бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам

Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам

Суралцагч шилжүүлэн суралцуулах журам

Хичээл дүйцүүлэх журам

МУИС-ийн суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам

5.5.1.3 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх

МУИС нь дараах үйл явцыг бий болгосон:

- багшлах
- суралцахуйг чиглүүлэх
- суралцахуйн захиргааны дэмжлэг

Лавлах баримт бичиг:

Процессын гарын авлага - Сургалтын тэнхимийн үйл явцын урсгал диаграмм (NUM/EOMS/PFC/001) Хавсралт-IX

Процессын гарын авлага – Үйл явц Багшлахуй ба суралцахуй үйл явц (NUM/EOMS/PFC/002) Хавсралт-X

Процессын гарын авлага – Оюутны хөгжлийн үйл явц урсгал диаграмм(NUM/EOMS/PFC/006) хавсралт-XIV

Процессын гарын авлага – Шалгалт үйл явцын урсгал диаграмм (NUM/EOMS/PFC/008) Хавсралт-XVI

Процессын гарын авлага - Эрдэм шинжилгээ үйл явцын урсгал диаграмм(NUM/EOMS/PFC/013) Хавсралт-XX

Процессын гарын авлага - Стратеги хөтөлбөр үйл явцын урсгал диаграмм(NUM/EOMS/PFC/015) Хавсралт-XXII

Процессын гарын авлага - Оюутны суралцахуй үйл явцын урсгал диаграмм (NUM/EOMS/PFC/016) Хавсралт-XXIII

5.5.1.4 Дүнгийн үнэлгээ

Сургалтын удирдлагын системийн программ хангамжаар дамжуулан суралцагчийн танилцуулсан ажил болон оноож буй үнэлгээний хооронд бодитой уялдаа холбоог тогтоох боломжтой байхаар дүнгийн хяналтыг мөшгөн баталгаажуулдаг.

Сургалтын удирдлагын системийн программ хангамж, тайлангийн картад өгсөн дүнгийн нотлох баримт болгон үнэлгээний баримтжуулсан мэдээллийг хадгалдаг.

Баримтжуулсан мэдээллийн хадгалалтын хугацааг портал/веб сайтаар дамжуулан нийтэд нээлттэй болгосон.

Хичээлийн жилийн шинэ улирлын төлөвлөлт

- Багш нарт хичээл хуваарилах

- Багшийг чиглүүлэх

-Хичээлийн агуулгын дагуу багшлах

-Оюутныг тогтмол үнэлэх

-Үнэлгээ, системд оруулах

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам

МУИС-д хичээл дүйцүүлэх журам

МУИС-ийн Суралцагчийн дадлагын журам

МУИС-ий Сургалтын үйл ажиллагааны журам

5.5.1.5 Үнэлгээ хийсэн сургалтыг батламжлах

МУИС нь хураангуй үнэлгээний дараа:

- Суралцагчдад үнэлгээний үйл ажиллагааны үр дүн, дүнгийн талаар оюутны портал болон тайлангийн хуудсаар дамжуулан мэдээлэх;
- Суралцагчдад их сургуулийн бодлогын дагуу дахин үнэлгээ хийлгэх хүсэлт гаргаж, үнэлгээний үйл ажиллагааны үр дүн болон дүнг засаж залруулах хүсэлт гаргах, хүсэлт гаргах боломж олгох;
- Суралцагчид өөрсдийн ажил, түүний нарийвчилсан үнэлгээтэй танилцаж, санал хүсэлтээ илэрхийлэх бүрэн боломж олгох;
- Үнэлгээний үр дүнгийн нотлох баримтыг суралцагчдад тайлангийн хуудас хэлбэрээр баримтжуулсан мэдээлэл болгон өгөх үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Дүгнэлт, эцсийн үнэлгээний шийдвэрийн үндэслэлийг сургалтын удирдлагын системийн программ хангамжийн баримтжуулсан мэдээлэл болгон хадгална;
- Баримтжуулсан мэдээлэл нь их сургуулийн бүртгэл хадгалах бодлогын дагуу тодорхой хугацаанд хадгалагдана;
- Ийм баримтжуулсан мэдээллийг хадгалах хугацааг вэбсайт / портал дээр нийтэлсэн.

5.5.1.6 Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага

Байгууллага боломжтой, тодорхой хугацаанд хийж болохоор өөрчлөлт тохируулгыг хэрэгжүүлнэ.

Сургалтыг хүргэх талаар: зорилтот бүлгийн суралцагчид чиглэсэн онцлог сургалтын стратегийг ашиглах, тусгай хэрэгцээт суралцагчдад зориулсан бие даан суралцахыг дэмжих арга хандлагыг ашиглана.

Сургалтын үнэлгээний хувьд: суралцагчдад сургалтын сэдвийг хэрхэн эзэмшсэн гэдгээ харуулах олон янзын боломжийг олгох, үнэлгээний зохих аргуудыг багтаасан хувь хүний арга хэмжээг уян хатан хэрэгжүүлнэ.

МУИС-ийн ОХГ нь хөгжлийн бэрхшээлтэй оюутныг дэмжих ажлын хүрээнд суралцагчдын эрхийг хангах, нийгмийн бүхий л харилцаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэх, зэрэг ойлголт хандлагыг төлөвшүүлэх, суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй оюутны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж хөтөлбөрийн хүрээнд:

- МУИС-д элсэн суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сургалт, эрдэм шинжилгээний орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зориулсан эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгох
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын тохируулга тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах, хүртээмжтэй болгох
- Суралцахуйг дэмжихэд нөлөөлөх дэд бүтцийг сайжруулж, таатай орчин бүрдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үзүүлэх дэмжлэг үйлчилгээ болон ажлын байранд зуучлах үйлчилгээг хэрэгжүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын талаарх мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг ажлыг зохион байгуулж байна.

Тохируулга тодорхойлох ярилцлагаар олон давтамжтайгаар дурдагдсан тохируулгууд:

- Ном цахим форматад хөрвүүлэх
- Шалгалтын цаг сунгах
- Дуут бичлэг хийх
- Багшийн лекцийг нэг өдрийн өмнө и-мэйлээр авах
- Тохиромжтой суудал сонгох
- Хичээл түрүүлж сонгох
- Ирцийн уян хатан байдал
- Хичээл хооронд бага зэргийн хоцролт
- Анги сонгох
- Эргономик компьютерын гар хулгана
- Эргономик сандал
- Багш тод, чанга, эгцэлж харсан байрлалд ярих

МУИС-ийн Ерөнхий суурийн хөтөлбөрийн түгээмэл хэрэглэгддэг зарим сурах бичгийг EPUB хүртээмжтэй хэлбэрт шилжүүлж сургалтад хэрэглэж эхэлсэн. Цаашид нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

МУИС-ийн хэмжээнд веб сайтын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулан "Web Content Accessibility Guidelines (WCAG)" стандартыг мөрдлөг болгож Оюутан, хөгжлийн газрын цахим хуудасны /student.num.edu.mn/ загварыг харааны бэрхшээлтэй суралцагчдад ойлгомжтой болгосон.

Хичээл сонголт. "МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам"-ын 4.3.21-д Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч үндсэн улирлын хичээл сонгон баталгаажуулах хугацаанаас 1

хоногийн өмнө сургалтын үйл ажиллагаа хариуцсан нэгжийн дэмжлэгтэйгээр хичээл сонгон баталгаажуулах давуу эрхтэй хичээл сонголт хийж байна.

Дотуур байр: “МУИС-ийн дотуур байрны журам”-ын 3.2.1-д МУИС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тусгай өрөөтэй байж болно гэж заасан. Суралцагч тухайн өрөөнд орох хүсэлтийг холбогдох материал –бүрдүүлэн заасан хугацаанд мэдээллийн системээр дамжуулан гаргана. 1-р түвшний суралцагчийн адил өрөө сонгодог. Зарим суралцагчийн хүсэлтийн дагуу холбогдох материалыг оюутны үйлчилгээ хариуцсан нэгжийн мэргэжилтэн хянаж, өрөөний хуваарилалтыг хийж баталгаажуулах боломжоор хангана

“Хамтдаа ярилцъя” бүлгийн зөвлөгөөнийг улирал бүр зохион байгуулж байна.

Бүлгийн уулзалт, зөвлөгөөнөөр: Өөрсдийн сэтгэл зүй, сэтгэл зүйн эрүүл мэндийн тухай ярилцах, Сэтгэл зүйн байдал, хүсэл зорилго, мэдрэмжээ зургаар илэрхийлэх гэх мэт бусад үйл ажиллагааг зохион байгуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас зохион байгуулсан “хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалт” төрөлд МУИС-ийн багш, оюутны хөгжлийн төвийн байр 2023 онд шалгарсан. МУИС-ийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжих, сургалтын орчин нөхцөлийг ээлтэй болгох зорилгоор МУИС-ийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан ярьдаг сонсдог ном бүхий өрөөг МУИС-ийн номын сангийн 1 дүгээр давхарт тохижуулсан.

Тус номын сан нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй суралцагч ашиглах бөгөөд хичээл, сургалтын тохируулга бүхий орчныг бүрдүүлж байгаагаараа онцлог юм.

Тэмдэглэгээ, мөшгөх боломж

МУИС нь тэмдэглэгээ, мөшгөх боломжийг дараах байдлаар батална. Үүнд:

- Нийт суралцагчдын өсөлт дэвшил, тохиромжтой бол, судлах хичээл эсвэл хөтөлбөрийг төгсгөсөн, дүүргэсэн, судалсан хүний суралцаж, ажиллаж байгаа замнал
- Багшийн ажлын гүйцэтгэлийг багшийн журнал хөтлөлт, хичээлийн бүртгэл, СиСи системийн ашиглалтаар
- Ажилтны ажлын гүйцэтгэлийг цагийн бүртгэл болон ажлын гүйцэтгэлийн тайлангаар
- Дүрэм, журмын хэрэгжилтийг үйл ажиллагаанд гарч буй эрсдэл боломжуудаар
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сургалтын үр дүнгээр

Сонирхогч талын өмч

МУИС аливаа сонирхогч этгээдийн өмчийг тухайн байгууллагын мэдэлд, эсвэл ашиглаж байгаа үед нь хамгаалдаг.

Сонирхсон этгээдийн эд хөрөнгө үрэгдүүлсэн, гэмтсэн, ашиглахад тохиромжгүй болсон тохиолдолд тухайн байгууллага холбогдох сонирхогч этгээдэд мэдээлж, зохих арга хэмжээг авна. Материал, эд анги, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, гэрчилгээ олгох үйл явц болон бусад холбогдох баримт бичиг зэрэг биет эд зүйлс алдагдсан, гэмтсэн тохиолдолд оюутны хотхоны үйлчилгээний үйл ажиллагааны гарын авлагад баримтжуулж, эдгээр тохиолдлын бүртгэлийг оюутны хотхоны үйлчилгээний хэлтэс хөтөлдөг.

Сонирхсон этгээдийн оюуны өмч болон хувийн мэдээллийг их сургуулийн мэдээллийн аюулгүй байдлын бодлогын дагуу удирддаг.

Лавлах баримт бичиг:

Их сургуулийн хотхоны үйлчилгээний үйл явцын гарын авлага-Хавсралт XIII

Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

5.5.2 Хамгаалалт

Байгууллага нь үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэх явцад гарсан бүтээгдэхүүнийг шаардлагад тохируулахын тулд шаардлагатай хэмжээгээр хадгална.

5.5.3 Суралцагчдын өгөгдлийн хамгаалалт, ил тод байдал

МУИС мэдээллийн технологийн талаар баримтжуулсан үйл явцын гарын авлагыг бий болгож, мөн суралцагчдын мэдээллийн хамгаалалт, ил тод байдлыг хангах мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлсэн. Процесс нь дараах зүйлийг баталгаажуулдаг:

- Суралцагчийн ямар мэдээлэл цуглуулж, тэдгээрийг хэрхэн, хаана боловсруулж хадгалдаг;
- Мэдээлэлд хандах эрхтэй хүмүүс;
- Ямар нөхцөлд суралцагчийн мэдээллийг гуравдагч этгээдтэй хуваалцах боломжтой;
- Өгөгдөл хэр удаан хадгалагддаг.

МУИС нь зөвхөн суралцагчдын тодорхой зөвшөөрлийн дагуу мэдээллийг цуглуулж, хуваалцаж, суралцагч болон бусад сонирхогч этгээдэд өөрсдийн өгөгдөлд хандах, мөн тодорхойлсон бодлого, удирдамжийн дагуу өөрсдийн өгөгдлийг засах, шинэчлэх боломжийг олгодог.

Байгууллага нь мэдээллийн аюулгүй байдал, хандалтын хяналтын бодлогын дагуу суралцагчдын мэдээлэлд зөвхөн эрх бүхий хүмүүс хандах боломжтой байхын тулд зохих бүх арга хэмжээг авдаг. Технологийн хамгаалалтын арга хэмжээг баталгаажуулсан. Мэдээллийн аюулгүй байдал, хандалтын хяналтын зөрчлийг тодорхойлсон бодлогын дагуу мэдээлж, мөрдөн шалгадаг.

Лавлах баримт бичиг:

Мэдээллийн технологийн процессын гарын авлага үйл явцын урсгал диаграмм хавсралт-XVII

5.5.4 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний өөрчлөлтийн хяналт

МУИС шаардлагад тохирч байгаа эсэхийг баталгаажуулахын тулд шаардлагатай үйлчилгээний өөрчлөлтийг хянаж, өөрчлөлтийн хяналтын үр дүн, өөрчлөлтийг зөвшөөрч буй ажилтнууд болон өөрчлөлтийн менежментийн журмын дагуу (NUM/EOMS/PRO/006) хянан үзэх явцад гарсан шаардлагатай арга хэмжээг тодорхойлсон баримтжуулсан мэдээллийг хадгална.

Лавлах баримт бичиг:

Өөрчлөлтийн менежментийн журам (NUM/EOMS/PRO/006) Хавсралт-VII

5.6 Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлж эхлэх

Суралцагчид, үйлчлүүлэгчдэд үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөлтийн үйл ажиллагааг хангалттай түвшинд гүйцэтгэж, холбогдох эрх мэдэлтэй тал, тохиромжтой бол суралцагчид, үйлчлүүлэгчид зөвшөөрөхөөс нааш нийлүүлэхгүй.

Байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлж эхэлсэн тухай баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

Баримтжуулсан мэдээлэлд:

- хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан нотолгоо
- нийлүүлж эхлэхийг зөвшөөрлийг олгосон хүний талаар мөшгөх боломжийн мэдээллийг багтаана.

5.7 Боловсролын гарцын үл тохирлын хяналт

МУИС-ын шаардлагад тохирохгүй байгаа гаралтыг тодорхойлж, тэдгээрийг зориулалтын бусаар ашиглах, хүргэхээс урьдчилан сэргийлэхийн тулд хяналтыг баталгаажуулдаг. Боловсролын үйлчилгээ, сургалтын хөтөлбөр, элсэлт, шалгалт, эрдэм шинжилгээний үйл явц дахь зөрчилтэй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тайлагнах, хянах, залруулах арга

хэмжээг "Үл тохирол бүхий гаралтын журам"-ын дагуу (NUM/EOMS/PRO/005) хэрэгжүүлдэг. Уг журам нь үйлчилгээ үзүүлэх явцад болон дараа нь илэрсэн шаардлага хангаагүй боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд мөн хамаарна.

Боловсролын үйлчилгээний үл тохирол буюу сургалтын хөтөлбөр, элсэлт, сургалт, төгсөлтийн үйл явцад гарсан бүхий л үл тохирлыг илрүүлж, хянах, залруулах, сэргийлэх үйл ажиллагаа нь дараах мөчлөгөөр тасралгүй явагдана. Үүнд:



Мэдэгдэж буй үл тохирол бүхий гаралтуудын хувьд МУИС тэдгээрийг дараах аргуудаас сонгож шийдвэрлэдэг:

- Залруулга;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээг тусгаарлах, хязгаарлах, буцаах буюу түр зогсоох;
- Суралцагчид болон бусад үр шим хүртэгчдэд мэдэгдэх;
- Концессоор хүлээн авах зөвшөөрөл авах.

Шаардлагад тохирч байгаа эсэх нь үл тохирлын үр дүнг засах үед эрх бүхий этгээд(үүд)-ээр баталгаажуулна.

МУИС нь дараах баримтжуулсан мэдээллийг хадгалдаг.

- Хөтөлбөрийг хүргэх талаар тайлбарласан;
- Үл тохирол бүхий гаралтуудыг тайлбарлах;
- Авсан арга хэмжээг тайлбарлах;
- Үл тохиролтой холбоотой арга хэмжээ авах эрх бүхий байгууллагыг тодорхойлох;

Лавлах баримт бичиг:

Үл тохирол бүхий гаралтын журам (NUM/EOMS/PRO/005)

БҮЛЭГ 6: ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (стандартын бүлэг 9)

6.1. Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээ

6.1.1. Ерөнхий зүйл

Монгол Улсын Их Сургууль (МУИС) нь боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны (ББМТ) гүйцэтгэл, үр нөлөөг баталгаажуулах зорилгоор мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг системтэйгээр хэрэгжүүлдэг.

Эдгээр үйл ажиллагаа нь дараах үндсэн зорилгыг агуулна:

- ББМТ-ны гүйцэтгэл, үр нөлөөг үнэлэх;

- Чанарын бодлого, стратеги, төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хянах;
- Сайжруулалт хийх боломжийг тодорхойлох;
- Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих.

МУИС-ийн Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь эдгээр үйл ажиллагааг “МУИС-ийн Хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээний журам”-ын дагуу гүйцэтгэдэг.

Журмаар дараах асуудлууд зохицуулагдана:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын бодлого, зорилго;
- Нэгжийн бүтэц, зохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлага;
- Бүрэлдэхүүн/салбар сургууль, хүрээлэн, төв, газар, нэгжүүдтэй хамтын ажиллагааны зохицуулалт;
- Аудитын үйл ажиллагааны талаар мэдээлэл, тайланг төвлөрүүлэх журам.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь:

- Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн үнэлгээний хэлбэрээр дотоод хяналт, аудит, үнэлгээний үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;
- Жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан боловсруулж, ректороор батлуулна;
- Үр дүнг дүн шинжилгээ хийж, удирдлагын дүн шинжилгээний үйл явцад ашиглана.

Мөн ББМТ-ны дагуу:

- Юуг мониторинг хийх, хэмжих шаардлагатайг тодорхойлно;
- Хүчин төгөлдөр үр дүн гаргах арга, хэмжүүр, шалгуурыг тогтооно;
- Хүлээн авах шалгуур, гүйцэтгэлийн зорилтот түвшнийг тогтооно;
- Мониторингийн дүн шинжилгээ, үнэлгээ хийх давтамжийг тогтооно.

Эдгээр үр дүн, нотолгоог баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр бүртгэж, хадгалдаг. Байгууллага нь ажилтнуудад өөрсдийн гүйцэтгэл, ажлын үр дүнг эргэцүүлэн тунгаах, бүтээлч байдлаар үнэлэх орчныг бүрдүүлж, энэ нь байгууллагын сайжруулалтад хувь нэмэр болдог.

6.1.2. Суралцагчид, үйлчлүүлэгчид, үр шим хүртэгчид, ажилтнуудын сэтгэл ханамж

6.1.2.1. Сэтгэл ханамжийн мониторинг:

МУИС нь хөтөлбөр, үйлчилгээ, сургалтын орчны чанарын талаар бодит мэдээлэл цуглуулах, сайжруулалтын чиглэлийг тодорхойлох зорилгоор суралцагчид, ажилтнууд, төгсөгчид, ажил олгогчид болон бусад үр шим хүртэгч талуудын сэтгэл ханамжийг тогтмол хянаж үнэлдэг.

Мэдээллийн төрөл	Мониторингийн арга	Үнэлгээний давтамж	Хариуцах нэгж
Суралцагчийн сэтгэл ханамж	Оюутны сэтгэл ханамжийн судалгаа	Улирал бүр	Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газар
Ажилтны сэтгэл ханамж	Ажилтны сэтгэл ханамжийн судалгаа	Жил бүр	Захиргаа, хүний нөөцийн газар
Төгсөгчийн сэтгэл ханамж	Төгсөгчийн судалгаа	Жил бүр	Оюутны хөгжлийн газар
Ажил олгогчийн сэтгэл ханамж	Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа	2 жил тутам	Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газар

а) Суралцагчийн сэтгэл ханамж:

Оюутны хөгжлийн газар нь жил бүр “Оюутны хөгжил, үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа”-г зохион байгуулж, оюутны амьдрал, үйлчилгээ, дотуур байр, дэмжих үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлдэг.

2024 онд хийгдсэн судалгаанд нийт 620 оюутан оролцож, 12 төрлийн үйлчилгээнд үнэлгээ өгсөн. Мөн дотуур байрны сэтгэл ханамжийн судалгаа жил бүр Sisi системээр хийгддэг.

б) Хөтөлбөрийн оролцогч талуудын үнэлгээ:

2018 оноос эхлэн МУИС-ийн сургалт хариуцсан нэгжүүд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг суралцагч, төгсөгч, ажил олгогчдоор үнэлүүлэх судалгааг тогтмол хийж байна. Эдгээр мэдээлэл нь хөтөлбөрийн дотоод хөндлөнгийн үнэлгээ, шинэчлэл, сайжруулалтын үндэслэл болдог. Зарим тэнхим энэхүү судалгааг бие даан зохион байгуулдаг.

в) Сэтгэл ханамжийн судалгааны хураангуй:

№	Судалгааны төрөл	Хичээлийн жил	Давтамж
1	Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа	2018–2019	Жил бүр
2	Хичээлийн сэтгэл ханамжийн судалгаа	Улирал бүр	Улирал бүр
3	Төгсөх түвшний суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа	2020–2024	Жил бүр
4	Төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа	2018, 2020	2 жил тутам
5	Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа	2018–2019	2 жил тутам

г) Ажилтны сэтгэл ханамж:

МУИС-ийн Захиргаа, хүний нөөцийн газар нь ажилтны сэтгэл ханамжийг судлан, ажлын орчин, урамшуулал, удирдлагын харилцаа, хөгжлийн боломж зэрэг хүчин зүйлсийг үнэлж, бодлого төлөвлөлтөд тусгадаг.

Судалгааг жил бүр хийж, үр дүнг удирдлагын дүн шинжилгээний үйл ажиллагаанд ашигладаг.

д) Зочин, гадаад түнш, хамтрагчдын сэтгэл ханамж:

Сургалт, хамтын ажиллагааны үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор зочин, хамтрагч байгууллагуудын санал хүсэлтийг жил бүр авч, үнэлдэг.

Мэдээллийн төрөл	Мониторингийн арга	Давтамж
Суралцагчийн сэтгэл ханамж	Судалгаа, ярилцлага	Улирал бүр
Ажилтны сэтгэл ханамж	Судалгаа, үнэлгээний хуудас, онлайн платформ	Жил бүр
Зочдын сэтгэл ханамж	Санал хүсэлтийн хуудас	Жил бүр
Төгсөгчийн сэтгэл ханамж	Судалгаа, онлайн платформ	Жил бүр

6.1.2.2. Өргөдөл, гомдлыг хянах:

МУИС нь өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх үйл явцыг “МУИС-ийн Албан хэрэг хөтлөлтийн журам”-аар зохицуулж, соёлтой, ил тод, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах орчныг бүрдүүлдэг.

Өргөдөл, гомдлын процесс дараах үе шатаар явагдана:

1. Өргөдөл, гомдлыг хүлээн авах;
2. Мөшгөх, бүртгэх, хүлээн зөвшөөрөх;
3. Анхан шатны үнэлгээ хийх;
4. Шалгах, хариу өгөх;
5. Шийдвэрээ мэдэгдэх;
6. Өргөдөл, гомдлыг хаах;
7. Баримтжуулсан мэдээллийг хадгалах.

Нууцлал ба шударга байдал: МУИС нь өргөдөл, гомдол гаргагчийн хувийн мэдээлэл, нууцлалыг хамгаалах, үнэлгээ, шийдвэрийн бодит байдлыг баталгаажуулах зарчмыг чанд мөрддөг.

2021 оноос хойш олон нийтийн санал хүсэлт, өргөдөл, лавлагаа мэдээллийг төвлөрүүлэн хүлээн авах зорилгоор call center байгуулах төлөвлөгөөг боловсруулж, 2022 онд техник тоног төхөөрөмжийн бэлтгэл ханган, Оюутны хөгжлийн төв хариуцан, холбогдох программ хангамжийг нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна.

Баримтжуулалт: Хүлээн авсан бүх өргөдөл, гомдол, санал хүсэлтийн мэдээлэл, тэдгээрийн шийдвэрийг нотолгоо болгон бүртгэж хадгалдаг.

6.1.3. Бусад мониторинг, хэмжилтийн хэрэгцээ

МУИС нь дараах санал хүсэлтийг холбогдох сонирхогч талуудаас хүсэж, зохих ёсоор нь нээлттэй болгохыг баталгаажуулдаг:

- Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх санал хүсэлт;
- Сургалтын тохиролцсон үр дүнд хүрэхэд тэдний үр дүнтэй байдлын талаарх санал хүсэлт;
- МУИС-ийн нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаарх санал хүсэлт.

Хүлээн авсан санал хүсэлтийн түвшинд мониторинг хийж, хангалтгүй тохиолдолд түүнийг нэмэгдүүлэх арга хэмжээ авдаг. Мониторинг, хэмжилтийн үйл ажиллагаанд дараах зүйлс орно:

- Тухайн хичээлийн хөтөлбөрийн агуулга, шинэчилсэн байдал;
- Ажлын ачаалал, суралцагчийн ахиц дэвшил, төгсөлтийн түвшин;
- Үнэлгээний үр дүнтэй байдал;
- Суралцагчид болон бусад үр шим хүртэгчдийн хөтөлбөртэй холбоотой сэтгэл ханамж;
- Сургалтын орчин, туслах үйлчилгээ, тэдгээрийн зорилгод нийцсэн байдал.

Холбогдох баримт бичиг:

Мониторинг, хэмжилтийн үр дүн.

6.1.4. Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний арга

МУИС дараах зүйлийг тодорхойлдог:

- Гүйцэтгэлийн талаарх мониторинг, шинжилгээний аргын мэдээллийг олж авах ;
- Гүйцэтгэлийг хэмжих зорилтууд.

МУИС нь дараах зүйлийг хангадаг:

- Үнэлгээнд хамрагдсан болон өртсөн сонирхогч талуудыг тодорхойлох;
- Үнэлгээг хийж байгаа хүмүүс чадварлаг, бодитой байх;
- Үнэлгээний тайлан ил тод, боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийн зорилго, үр дүн, түүнчлэн дүгнэлтийг тайлбарлахад ашигласан хэтийн төлөв, арга, үндэслэлийг тодорхой тусгасан байх;
- Боловсролын үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг (жишээ нь, сургалтын орчин) хангалттай нарийвчлан судалж, боловсролын үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох боломжтой байх.

6.1.5. Дүн шинжилгээ/анализ/ ба үнэлгээ

МУИС хэмжилт, мониторингийн үйл ажиллагаанаас үүсэх бүх өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үнэлдэг. Шинжилгээний үр дүнг үнэлэхэд дараах зүйлүүдийг ашигладаг:

- Бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирол;
- Үр шим хүртэгчийн сэтгэл ханамжийн түвшин;
- Ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшин;
- Менежментийн тогтолцооны гүйцэтгэл, үр нөлөө;
- Эрсдэл, боломжуудыг шийдвэрлэхийн тулд авсан арга хэмжээний үр нөлөө;
- Гаднын үйлчилгээ үзүүлэгчдийн гүйцэтгэл;
- Байгууллагын менежментийн тогтолцоог сайжруулах шаардлага.

Баримтжуулалт: Харьяа нэгжид хийсэн хяналт шалгалт, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг нэгтгэн зохих стандарт, журмын дагуу цахим болон цаасан хэлбэрээр архивын нэгж үүсгэж хадгалдаг.

Холбогдох баримт бичиг:

Мониторинг, хэмжилтийн үр дүн.

6.2. Дотоод аудит

МУИС нь боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны (ББМТ) шаардлагуудын хэрэгжилт, үр нөлөөг баталгаажуулах зорилгоор дотоод аудитыг тогтмол зохион байгуулдаг.

- Дотоод аудитуудыг албан ёсны сургалтад хамруулж, гэрчилгээ олгосон бөгөөд тэдгээр нь ББМТ болон холбогдох журам, стандартын шаардлагууд хэрхэн хэрэгжиж байгааг үнэлдэг;
- Дотоод аудит нь төлөвлөгөөт байдлаар жилд нэг удаа хийгддэг;
- Аудитын шалгуур үзүүлэлт, хамрах хүрээ, аргачлалыг батлагдсан “Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитын журам”-аар тодорхойлно.

Аудитын явцад илэрсэн үл тохирол болон сайжруулах боломжийг баримтжуулж хадгалдаг бөгөөд холбогдох нэгжүүд дараах үүрэг хүлээдэг:

- Илэрсэн үл тохирлыг арилгах, шалтгааныг тодорхойлох;
- Залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Арга хэмжээний үр дүнгийн тайланг аудитын багт ирүүлэх.

Аудитын бүх үйл явц болон түүний нотолгоог “Дотоод аудитын тайлан”, “Үл тохирлын бүртгэл” хэлбэрээр баримтжуулж хадгална.

Холбогдох баримт бичиг:

Дотоод аудитын журам (NUM/EOMS/PRO/004) Хавсралт -XXX

6.3. Менежментийн дүн шинжилгээ

МУИС-ийн дээд удирдлага нь боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны (ББМТ) үр нөлөөг үнэлэх, байнгын сайжруулалтыг хангах, түүний дотор:

- ББМТ нь МУИС-ийн бодлого, стратегийн чиг хандлагатай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах;
- Тогтолцооны үр нөлөө, уялдаа, тууштай байдлыг үнэлэх;
- Сайжруулалт хийх боломж, шаардлагатай өөрчлөлтийг тодорхойлох зорилгоор жилд нэгээс доошгүй удаа менежментийн дүн шинжилгээг зохион байгуулна.

6.3.1 Менежментийн дүн шинжилгээ оролт (Input):

Менежментийн дүн шинжилгээний орц нь дараах мэдээллийг хамарна:

- Гадаад ба дотоод аудитын үр дүн;
- Үл тохирол ба залруулах арга хэмжээний байдал;
- Үйлчлүүлэгч, суралцагч, ажилтны санал, гомдол, сэтгэл ханамжийн судалгааны дүн;
- Үйл явцын гүйцэтгэл, бүтээгдэхүүн болон үйлчилгээний тохирлын байдал;
- Эрсдэл ба боломжийн удирдлагын хэрэгжилтийн дүн;
- Өмнөх дүн шинжилгээний мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилт;
- Чанарын бодлого, зорилтын хэрэгжилтийн түвшин;
- Хууль, эрх зүйн орчны болон зохион байгуулалтын өөрчлөлт;
- Чанарын тогтолцоог сайжруулах санал, зөвлөмж.
-

6.3.2. Удирдлагын дүн шинжилгээний гаралт (Output):

Дүн шинжилгээний хурлын гарц нь дараах үр дүнг агуулна:

- Сайжруулалт хийх тодорхой арга хэмжээ, санал;

- Чанарын зорилтуудыг шинэчлэх, нарийвчлах шаардлага;
- ББМТ-д өөрчлөлт оруулах хэрэгцээ, нөөцийн шинэ шаардлага;
- ББМТ-ийн сайжруулалтын чиглэл, хөтөлбөрийн зөвлөмж.

Баримтжуулалт: Удирдлагын дүн шинжилгээний хурал, шийдвэр, гарсан санал, арга хэмжээний төлөвлөгөөг “Удирдлагын дүн шинжилгээний тэмдэглэл” хэлбэрээр баримтжуулж, нотлох баримт болгон хадгална.

Холбогдох баримт бичиг:

Менежментийн дүн шинжилгээний журам (NUM/EOMS/PRO/001) Хавсралт- XXXI

БҮЛЭГ 7: САЙЖРУУЛАЛТ (ISO 21001:2018 стандарт, бүлэг 10)

7.1 Үл тохирол ба залруулах арга хэмжээ

МУИС нь дараах хандлагыг тодорхойлсон залруулах арга хэмжээний журмыг дагаж мөрддөг. Үүнд:

Үл тохиролд хариу үйлдэл үзүүлэх:

- Үл тохирлыг хянах, залруулах арга хэмжээ авах;
- Үр дагаврыг авч үзэх;

Үл тохирлын шалтгааныг арилгах:

- Үл тохирлыг шинжлэх ба шалтгааны тогтоох;
- Үүнтэй төстэй үл тохирол байгаа эсэхийг тодорхойлох.
- Шаардлагатай аливаа арга хэмжээг хэрэгжүүлэх ба үр нөлөөг шинжлэх.
- Шаардлагатай тохиолдолд менежментийн тогтолцоонд өөрчлөлт оруулах.

Байгууллага нь гарсан үл тохирлын үр дагаварт тохирсон бүх залруулах арга хэмжээг баталгаажуулдаг.

Холбогдох баримт бичиг:

Залруулах арга хэмжээний журам (NUM/EOMS/PRO/003)-Хавсралт- XXXIII

7.2 Тасралтгүй сайжруулалт

МУИС нь байнгын мониторинг, үнэлгээ, дотоод аудит, менежментийн дүн шинжилгээгээр дамжуулан сайжруулах боломжуудыг тодорхойлж, сонгодог. Мөн суралцагч болон бусад хүлээн авагчийн шаардлагыг хангах, суралцагчид, бусад үр шим хүртэгчид, ажилтнууд болон бусад холбогдох сонирхогч талууд, түүний дотор гаднын үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Шаардлагад нийцүүлэн, ирээдүйн хэрэгцээ, хүлээлтийг хангахын тулд бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах;
- Хүсээгүй үр дагаврыг арилгах, урьдчилан сэргийлэх, бууруулах;
- Менежментийн тогтолцооны гүйцэтгэл, үр нөлөөг сайжруулах.

ХАВСРАЛТ

Хавсралт I:	ББМТ-ны хамрах хүрээ Дараалал ба харилцан үйлчлэл МУИС-ийн Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого Зөвшөөрлийн мэдэгдэл
Хавсралт II:	Эрсдэлийн менежментийн журам Өөрчлөлтийн менежментийн журам Дотоод аудитын журам Залруулах арга хэмжээний журам Менежментийн дүн шинжилгээний журам Үл тохирол бүхий гаралтын журам Баримтжуулсан мэдээлэлд хяналт тавих журам
Хавсралт II:	Байгууллагын бүтцийн диаграмм Хүний нөөцийн гарын авлага -урсгал диаграмм Сургалтын тэнхимийн үйл явцын гарын авлага урсгал диаграмм Багшлахуй ба суралцахуй үйл явцын гарын авлага урсгал диаграмм Элсэлтийн үйл явцын гарын авлага урсгал диаграмм Төгсөгчидтэй хамтран ажиллах үйл явцын гарын авлага урсгал диаграмм Их сургуулийн хотхоны үйлчилгээний үйл явцын гарын авлага урсгал диаграмм Оюутны хөгжлийн үйлчилгээний үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Аж ахуй, эд хөрөнгө” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Шалгалт” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Мэдээллийн технологи” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Маркетинг” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Худалдан авалт” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Эрдэм шинжилгээ” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Спорт” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Стратеги хөтөлбөр” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Оюутны суралцахуй” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Оюутны хөгжлийн болон соёл, олон нийтийн үйл ажиллагаа” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Сургалт” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “МАРКЕТИНГ-ЭЛСЭЛТ” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Ашиглалт” үйл явцын гарын авлага урсгал диаграмм “Агуулах, нөөц” үйл явцын гарын авлага урсгал диаграмм